



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ашигт малтмал, газрын тосны газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** САГ-2026/19/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)  
Улаанбаатар хот  
2026 он

Санхүүгийн аудитын газрын захирал,  
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг  
Утас:261665 Цахим хаяг: [naranchimegts@audit.gov.mn](mailto:naranchimegts@audit.gov.mn)  
Аудитын менежер: Д.Энхдалай  
Утас:260512 Цахим хаяг: [enkhdalaid@audit.gov.mn](mailto:enkhdalaid@audit.gov.mn)  
Ахлах аудитор: А.Даваадорж  
Утас: 261628 Цахим хаяг: [davaadorja@audit.gov.mn](mailto:davaadorja@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**АГУУЛГА**

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....	14
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....	14
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	15
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	16
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	17
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	24
4.1 Ерөнхий зүйл.....	24
4.2 Материаллаг байдал .....	24
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	24
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	24
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	29
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	30
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	31
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	38

**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АМГТГ	Ашигт малтмал, газрын тосны газар
ЗГНХ	Засгийн газрын нөөц хөрөнгө
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
НА	Нийцлийн аудит
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТЗ	Төрийн захиргаа
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТӨХХК	Төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТҮ	Төрийн үйлчилгээ
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ҮОМШӨ	Үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,  
Цахим шуудан: info@audit.gov.mn,  
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.23 № 06/267

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ашигт малтмал, газрын тосны газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

### Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн дараах зөрчлүүд нь бидний тогтоосон 3,349,420.2 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаараа болон нийлбэр дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөө үзүүлэхүйц байна. Үүнд:

- Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлсэн 13,856,504.3 мянган төгрөгийн хайгуулын ажлын зардлын нөхөн төлбөртэй холбоотой авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй;
- Бараа материалын нөөц дансанд бүртгэлтэй 23,175,390.3 мянган төгрөгийн өртөгтэй улсын нөөцийн шатахууныг өнөөгийн бодит өртгөөр (үнэ цэнээр) дахин үнэлж бүртгэлд тусгаагүй;
- Шатахууны нөөц, борлуулалт, тооцооны бүртгэлтэй холбоотой 9,821,992.9 мянган төгрөгийн авлага, өглөгийг санхүүгийн тайландаа бүртгээгүй;
- Авлагын дансны бүртгэл, баталгаажуулалт хангалтгүйгээс 8,109,827.4 мянган төгрөгийн үлдэгдэл бодитой эсэх нь нотлогдоогүй;

- Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дуусаж, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн боловч ашиглагдаж байгаа 8,884,034.3 мянган төгрөгийн дансны үнэ бүхий хөрөнгийг бодит үнэ цэнээр нь үнэлж бүртгээгүй байна.

Эдгээр зөрчил нь санхүүгийн тайланд өргөн тархаагүй боловч Төсвийн тухай хуулийн 6, 16 дугаар зүйл, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд заасан шаардлагад нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, оршин байх, үнэлгээ, ангилал ба толилуулгын батламж мэдэгдлийг хангаагүй байна.

### **Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 34 дүгээр тогтоолоор иргэний агаарын тээврийн тогтвортой үйл ажиллагааг хангах, агаарын хөлгийн түлшний хомсдол, тасалдал үүсэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор “Газрын тосны бүтээгдэхүүний улсын нөөцийг сэлгэн хадгалах гэрээ”-ний дагуу аж ахуйн нэгжүүдэд хадгалагдаж байгаа зуны дизель түлшний нөөцөөс 5,191.6 тонн түлшийг зах зээлийн үнээр зээлээр худалдан борлуулж, уг борлуулалтын орлогоор агаарын хөлгийн “ТС-1” түлшний улсын нөөцийг бүрдүүлэхээр шийдвэрлэсэн бөгөөд тус шийдвэрийн дагуу “Эрчис-Ойл” ТӨХХК-д холбогдох үүргийг өгч, тайлант хугацаанд 6 компанийн хадгалалтад байсан нийт 3,506.8 тонн дизель түлшийг хүлээн авч, 9,821,992.9 мянган төгрөгийн борлуулалт хийсэн байна.

### **Аудитын гол асуудал**

Хайгуулын тусгай зөвшөөрөл шинээр олгох сонгон шалгаруулалтыг 2025 онд 18 удаа зохион байгуулж, нийт 1.0 сая га бүхий 269 талбайгаас 573.5 мянган га талбайд хамаарах 128 тусгай зөвшөөрөл олгож, улсын төсөвт 137,895,940.8 тэрбум төгрөгийг төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөг 5 дахин давуулан биелүүлсэн байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Монгол Улсад нүүрсний давхаргын метан хийн хэвтээ өрөмдлөгийг анх удаа хэрэгжүүлж, туршилтын олборлолтыг эхлүүлсэн байна. Тодруулбал, “Метан Газ” ХХК нь Redlake-001-3b-Hz-01 болон Redlake-001-3b-Hz-02 цооногуудад 2025 оны 06 дугаар сарын 09-ний өдөр хэвтээ өрөмдлөгийн туршилтын ажлыг эхлүүлж, 2025 оны 08 дугаар сарын 18-ны өдрөөс метан хий ялгарч эхэлсэн бөгөөд тайлант хугацааны эцсийн байдлаар тогтвортой хийн гарцтай байна.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	32,538,151,642.96	33,141,040,324.19
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	179,712,640.00	-
31200	Банканд байгаа бэлэн мөнгө	179,712,640.00	-
31210	Төгрөг	179,712,640.00	-
31211	Төрийн сангийн харилцах	179,712,640.00	-
33	АВЛАГА	8,113,797,365.86	9,252,835,593.24
33300	Татаас, санхүүжилтийн авлага	-	1,133,122,664.00
33500	Бусад авлага	8,113,797,365.86	8,119,712,929.24
33510	Байгууллагаас авах авлага	8,113,797,365.86	8,119,712,929.24
34	УРЬДЧИЛГАА	408,396,000.63	48,670,519.24
34600	Урьдчилж гарсан зардал	406,986,442.51	27,841,665.23
34710	Урьдчилгаа тооцоо	1,409,558.12	20,828,854.01
34711	Бараа материал бэлтгэх урьдчилгаа	1,409,558.12	1,028,854.01
34712	Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	-	19,800,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	660,855,283.19	664,143,858.43
35400	Хангамжийн материал	660,855,283.19	664,143,858.43
35410	Бичиг хэргийн материал	9,134,952.36	4,196,782.85
35420	Аж ахуйн материал	570,822,366.64	573,641,869.99
35430	Сэлбэг хэрэгсэл	28,373,819.91	35,036,319.91
35440	Түлш, шатах тослох материал	1,255,324.28	-
35470	Бусад хангамжийн материал	51,268,820.00	51,268,885.68
36	НӨӨЦИЙН БАРАА	23,175,390,353.28	23,175,390,353.28
36400	Шатахууны нөөц	23,175,390,353.28	23,175,390,353.28
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	5,085,628,456.69	5,553,977,261.19
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	5,085,628,456.69	5,553,977,261.19
39200	Биет хөрөнгө	4,775,665,759.57	5,288,330,124.01
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,042,801,473.59	3,042,801,473.59
39202	Хуримтлагдсан элэгдэл	(532,868,543.01)	(606,030,191.81)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	2,256,083,697.95	2,785,189,355.55
39204	Хуримтлагдсан элэгдэл	(1,391,997,848.21)	(1,354,754,322.61)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	6,656,629,122.82	6,894,506,774.82
39206	Хуримтлагдсан элэгдэл	(5,754,870,072.83)	(5,959,993,013.90)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	985,249,779.81	987,519,379.81
39208	Хуримтлагдсан элэгдэл	(907,234,249.25)	(918,350,731.84)
39214	Бусад үндсэн хөрөнгө	956,438,687.47	956,438,687.47
39215	Хуримтлагдсан элэгдэл	(534,566,288.77)	(538,997,287.07)
39300	Биет бус хөрөнгө	309,962,697.12	265,647,137.18
39301	Программ хангамж	1,584,137,021.05	1,603,637,021.05
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,461,044,563.93)	(1,494,767,483.87)
39303	Бусад биет бус хөрөнгө	186,870,240.00	156,777,600.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2</b>	<b>37,623,780,099.65</b>	<b>38,695,017,585.38</b>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	179,812,640.00	1,256,034,494.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	179,812,640.00	1,256,034,494.00
41300	Өглөг	179,812,640.00	1,256,034,494.00
41360	Бусад өглөг	179,812,640.00	1,256,034,494.00
41361	Байгууллагад төлөх өглөг	179,812,640.00	1,255,935,494.00
41364	НДШ-ийн өглөг /ТӨҮГ/	-	99,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	37,443,967,459.65	37,438,983,091.38
51	Засгийн газрын хувь оролцоо	37,443,967,459.65	37,438,983,091.38
51100	Засгийн газрын оруулсан капитал	10,187,812,519.22	10,187,812,519.22
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	10,187,812,519.22	10,187,812,519.22

51200	Хуримтлагдсан үр дүн	24,810,711,556.65	24,805,727,188.38
51210	Өмнөх үеийн үр дүн	25,092,592,480.84	24,780,618,916.63
51220	Тайлант үеийн үр дүн	(281,880,924.19)	25,108,271.75
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,445,443,383.78	2,445,443,383.78
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5</b>	<b>37,623,780,099.65</b>	<b>38,695,017,585.38</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	334,660,144,064.74	434,656,541,567.91
11	ТАТВАРЫН ОРЛОГО	45,809,851,469.10	48,990,780,964.91
118	Бусад татвар, төлбөр, хураамж	45,809,851,469.10	48,990,780,964.91
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	45,809,851,469.10	48,990,780,964.91
118002	Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр	41,866,424,599.48	45,776,166,273.81
118003	Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн ордын нөхөн төлбөр	3,943,426,869.62	3,214,614,691.10
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	281,430,882,899.64	385,665,760,603.00
120	Нийтлэг татварын бус орлого	281,430,882,899.64	377,911,173,411.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	43,452,355,879.15	145,633,512,264.48
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	38,454,858,340.01	141,668,190,543.48
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,997,497,539.14	3,965,321,721.00
120006	Газрын тосны орлого	237,846,206,195.49	231,865,043,629.53
120009	Бусад орлого	180,000.00	513,258.22
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	130,600,000.00	-
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	1,540,825.00	412,104,258.77
121	Хөрөнгийн орлого	-	8,060,000.00
121001	Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого	-	8,060,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	7,419,409,696.00	7,746,527,192.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	7,135,094,800.00	7,668,693,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	7,135,094,800.00	7,668,693,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	284,314,896.00	77,833,292.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	31,385,096.00	58,566,876.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	252,929,800.00	19,266,416.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	334,942,024,988.93	434,631,433,296.16
21	УРСГАЛ ЗАРДАЛ	334,942,024,988.93	434,631,433,296.16
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	8,753,201,261.38	8,721,234,360.33
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,921,631,594.78	5,819,849,349.58
210101	Үндсэн цалин	2,927,902,148.17	3,322,280,859.40
210102	Нэмэгдэл	765,064,106.61	850,666,180.18
210103	Унаа хоолны хөнгөлөлт	794,314,500.00	1,187,823,500.00
210104	Урамшуулал	434,350,840.00	459,078,810.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	618,940,123.60	726,486,477.82
210201	Тэтгэврийн даатгалын зардал	423,455,362.03	495,611,490.24
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	49,585,906.28	58,753,068.92

210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	24,615,335.31	28,973,934.57
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	24,253,536.23	28,629,596.85
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	97,029,983.75	114,518,387.24
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	115,780,741.40	81,315,032.67
210301	Гэрэл, цахилгаан	15,475,296.60	14,655,165.00
210302	Түлш, халаалт	29,065,064.73	28,622,374.90
210303	Цэвэр, бохир ус	3,499,330.07	3,289,492.77
210304	Байрны түрээс	67,741,050.00	34,748,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	167,207,364.30	119,710,205.88
210401	Бичиг хэрэг	24,899,613.69	22,543,708.53
210402	Тээвэр, шатахуун	27,661,076.17	15,589,599.96
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	62,529,012.25	67,418,990.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	198,200.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	20,092,760.00	14,157,907.39
210408	Бараа материал акталсны зардал	31,826,702.19	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,047,100.00	486,400.00
210604	Урсгал засвар	3,047,100.00	486,400.00
2107	Томилолт, зочны зардал	73,645,440.00	57,593,596.00
210702	Дотоод албан томилолт	73,645,440.00	57,593,596.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,245,131,233.73	1,472,870,771.50
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,205,784,359.98	1,409,600,162.25
210803	Даатгалын үйлчилгээ	9,999,635.00	24,670,791.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	2,107,100.00	10,733,959.25
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	492,575.00	330,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	24,698,063.75	26,084,079.00
210807	Газрын төлбөр	1,939,500.00	45,980.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	110,000.00	1,405,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	607,817,663.57	442,922,526.88
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,881,332.52	10,100,431.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	45,500,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	596,936,331.05	387,322,095.88
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	326,188,823,727.55	425,910,198,935.83
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	200,000,000.00	-
21311	Засгийн газрын дотоод шилжүүлэг	200,000,000.00	-
213101	Бусад засгийн газрын дотоод шилжүүлэг	200,000,000.00	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	643,778,236.28	1,216,466,308.46
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	415,753,838.28	1,075,288,116.46
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	26,474,500.00	103,844,900.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	201,549,898.00	37,333,292.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	325,040,435,742.77	424,693,732,627.37
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,898,511,665.94	-
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	3,710,598.00	-
213306	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг	322,138,213,478.83	424,693,732,627.37
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	304,609,748.50	-
213404	Хөрөнгийн	304,609,748.50	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	(281,880,924.19)	25,108,271.75
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	(281,880,924.19)	25,108,271.75

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	334,724,700,924.30	435,197,637,332.92
11	ТАТВАРЫН ОРЛОГО	45,809,851,469.10	48,990,780,964.91
118	Бусад татвар, төлбөр, хураамж	45,809,851,469.10	48,990,780,964.91
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	45,809,851,469.10	48,990,780,964.91
118002	Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр	41,866,424,599.48	45,776,166,273.81
118003	Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн ордын нөхөн төлбөр	3,943,426,869.62	3,214,614,691.10
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	281,495,439,759.20	386,206,856,368.01
120	Нийтлэг татварын бус орлого	281,495,439,759.20	378,452,219,176.01
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	43,649,053,563.71	146,586,872,288.48
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	38,533,233,967.33	142,621,550,567.48
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,115,819,596.38	3,965,321,721.00
120006	Газрын тосны орлого	237,846,206,195.49	231,865,043,629.53
120009	Бусад орлого	180,000.00	303,258.00
121	Хөрөнгийн орлого	-	8,110,000.00
121001	Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого	-	8,110,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	7,419,409,696.00	7,746,527,192.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	7,135,094,800.00	7,668,693,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	7,135,094,800.00	7,668,693,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	252,929,800.00	77,833,292.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	31,385,096.00	58,566,876.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	221,544,704.00	19,266,416.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	334,682,161,309.68	435,377,349,972.92
21	УРСГАЛ ЗАРДАЛ	334,682,161,309.68	435,377,349,972.92
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	8,138,420,147.87	8,667,601,907.35
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,921,621,594.78	5,830,279,471.99
210101	Үндсэн цалин	2,927,892,148.17	3,326,262,636.35
210102	Нэмэгдэл	765,064,106.61	868,417,157.45
210103	Унаа хоолны хөнгөлөлт	794,314,500.00	1,187,823,500.00
210104	Урамшуулал	434,350,840.00	447,776,178.19
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	618,940,123.60	726,309,177.82
210201	Тэтгэврийн даатгалын зардал	423,455,362.03	495,465,870.24
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	49,585,906.28	58,745,148.92
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	24,615,335.31	28,969,974.57
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	24,253,536.23	28,625,636.85
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	97,029,983.75	114,502,547.24
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	115,780,741.40	81,315,032.67
210301	Гэрэл, цахилгаан	15,475,296.60	14,655,165.00
210302	Түлш, халаалт	29,065,064.73	28,622,374.90
210303	Цэвэр, бохир ус	3,499,330.07	3,289,492.77
210304	Байрны түрээс	67,741,050.00	34,748,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	129,554,948.25	130,143,181.00

Ашигт малтмал, газрын тосны газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210401	Бичиг хэрэг	18,266,000.00	22,543,649.00
210402	Тээвэр, шатахуун	28,537,300.00	15,589,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	62,529,012.25	67,418,990.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	198,200.00	4,000,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	20,024,436.00	20,590,942.00
2105	Нормативт зардал	4,889,000.00	2,750,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,889,000.00	2,750,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	24,280,900.00	5,762,700.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	6,365,300.00	1,793,300.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	3,483,000.00
210604	Урсгал засвар	17,915,600.00	486,400.00
2107	Томилолт, зочны зардал	73,645,440.00	75,129,481.00
210702	Дотоод албан томилолт	73,645,440.00	75,129,481.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,227,592,254.82	1,782,652,960.87
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,174,937,549.07	1,715,312,042.62
210803	Даатгалын үйлчилгээ	23,032,467.00	27,931,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	2,107,100.00	10,733,959.25
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	492,575.00	330,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	24,698,063.75	26,894,079.00
210807	Газрын төлбөр	1,939,500.00	45,980.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	385,000.00	1,405,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	22,115,145.02	33,259,902.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	22,115,145.02	10,385,787.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	22,874,115.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	326,543,741,161.81	426,709,748,065.57
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	200,000,000.00	258,232,902.27
21311	Засгийн газрын дотоод шилжүүлэг	200,000,000.00	258,232,902.27
213101	Бусад засгийн газрын дотоод шилжүүлэг	200,000,000.00	258,232,902.27
2132	Бусад урсгал шилжүүлэг	998,695,670.54	882,892,774.20
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	770,424,372.54	741,714,582.20
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	26,474,500.00	103,844,900.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	201,796,798.00	37,333,292.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	325,040,435,742.77	424,693,732,627.37
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,898,511,665.94	2,161,354,231.45
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	3,710,598.00	-
213306	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг	322,138,213,478.83	425,568,622,389.10
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	304,609,748.50	-
213404	Хөрөнгийн	304,609,748.50	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	42,539,614.62	(179,712,640.00)
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	385,069,431.79	
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	385,069,431.79	
2200	Дотоод эх үүсвэрээр	385,069,431.79	
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	385,069,431.79	
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(385,069,431.79)	

VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	(342,529,817.17)	(179,712,640.00)
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	522,242,457.17	179,712,640.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	179,712,640.00	-

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны нэр, төрөл	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	10,187,812,519.22	2,445,443,383.78	25,092,592,480.84	37,725,848,383.84
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	10,187,812,519.22	2,445,443,383.78	25,092,592,480.84	37,725,848,383.84
Тайлант үеийн үр дүн	-	-	(281,880,924.19)	(281,880,924.19)
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	10,187,812,519.22	2,445,443,383.78	24,810,711,556.65	37,443,967,459.65
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	10,187,812,519.22	2,445,443,383.78	24,810,711,556.65	37,443,967,459.65
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	(30,092,640.02)	(30,092,640.02)
Тайлант үеийн үр дүн	-	-	25,108,271.75	25,108,271.75
2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	10,187,812,519.22	2,445,443,383.78	24,805,727,188.38	37,438,983,091.38

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	<b>13,389,302,700.00</b>	<b>9,292,948,749.55</b>	<b>4,096,353,950.45</b>	<b>69.4</b>
Татварын бус орлого	13,389,302,700.00	9,292,948,749.55	4,096,353,950.45	69.4
Нийтлэг татварын бус орлого	5,426,954,400.00	3,965,321,721.00	1,461,632,679.00	73.1
Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/	5,426,954,400.00	3,965,321,721.00	1,461,632,679.00	73.1
Тусламжийн орлого	7,962,348,300.00	5,327,627,028.55	2,634,721,271.45	66.9
Төсвөөс санхүүжих	7,962,348,300.00	5,327,627,028.55	2,634,721,271.45	66.9
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>13,389,302,700.00</b>	<b>9,472,661,389.55</b>	<b>3,916,641,310.45</b>	<b>70.7</b>
УРСГАЛ ЗАРДАЛ	13,389,302,700.00	9,472,661,389.55	3,916,641,310.45	70.7
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	10,220,399,400.00	8,622,101,907.35	1,598,297,492.65	84.4
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	6,071,444,400.00	5,829,422,004.99	242,022,395.01	96.0
Үндсэн цалин	3,486,954,000.00	3,325,405,169.35	161,548,830.65	95.4
Нэмэгдэл	1,110,900,900.00	1,187,823,500.00	(76,922,600.00)	106.9
Унаа хоолны хөнгөлөлт	899,718,400.00	868,417,157.45	31,301,242.55	96.5
Урамшуулал	573,871,100.00	447,776,178.19	126,094,921.81	78.0
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	785,464,500.00	726,076,644.82	59,387,855.18	92.4
Тэтгэврийн даатгал	534,168,600.00	495,233,337.24	38,935,262.76	92.7
Тэтгэмжийн даатгал	62,855,500.00	58,745,148.92	4,110,351.08	93.5
ҮОМШӨ-ний даатгал	31,414,000.00	28,969,974.57	2,444,025.43	92.2
Ажилгүйдлийн даатгал	31,405,400.00	28,625,636.85	2,779,763.15	91.1
Эрүүл мэндийн даатгал	125,621,000.00	114,502,547.24	11,118,452.76	91.1
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	161,030,000.00	81,315,032.67	79,714,967.33	50.5
Гэрэл, цахилгаан	47,665,500.00	14,655,165.00	33,010,335.00	30.7
Түлш, халаалт	58,019,900.00	28,622,374.90	29,397,525.10	49.3
Цэвэр, бохир ус	8,286,000.00	3,289,492.77	4,996,507.23	39.7
Байрны түрээс	47,058,600.00	34,748,000.00	12,310,600.00	73.8
Хангамж, бараа материалын зардал	141,648,200.00	126,143,181.00	15,505,019.00	89.1
Бичиг хэрэг	23,909,800.00	22,543,649.00	1,366,151.00	94.3
Тээвэр, шатахуун	16,768,600.00	15,589,600.00	1,179,000.00	93.0
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	76,263,400.00	67,418,990.00	8,844,410.00	88.4
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	268,900.00	-	268,900.00	-
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	24,437,500.00	20,590,942.00	3,846,558.00	84.3
Нормативт зардал	3,875,000.00	2,750,000.00	1,125,000.00	71.0
Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,875,000.00	2,750,000.00	1,125,000.00	71.0
Эд хогшил, урсгал засварын зардал	11,254,700.00	5,762,700.00	5,492,000.00	51.2
Багаж, техник, хэрэгсэл	1,793,300.00	1,793,300.00	-	100.0
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	8,975,000.00	3,483,000.00	5,492,000.00	38.8
Урсгал засвар	486,400.00	486,400.00	-	100.0
Томилолт, зочны зардал	57,593,600.00	57,593,596.00	4.00	100.0
Дотоод албан томилолт	57,593,600.00	57,593,596.00	4.00	100.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,977,703,200.00	1,782,652,960.87	1,195,050,239.13	59.9

Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,901,101,200.00	1,715,312,042.62	1,185,789,157.38	59.1
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,030,700.00	-	1,030,700.00	-
Даатгалын үйлчилгээ	27,931,100.00	27,931,100.00	-	100.0
Тээврийн хэрэгслийн татвар	11,414,300.00	10,733,959.25	680,340.75	94.0
Тээврийн хэрэгслийн оношилгоо	679,000.00	330,000.00	349,000.00	48.6
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	31,533,200.00	26,894,079.00	4,639,121.00	85.3
Газрын төлбөр	1,738,200.00	45,980.00	1,692,220.00	2.6
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	2,275,500.00	1,405,800.00	869,700.00	61.8
Бараа үйлчилгээний бусад зардал	10,385,800.00	10,385,787.00	13.00	100.0
Бараа үйлчилгээний бусад зардал	10,385,800.00	10,385,787.00	13.00	100.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,168,903,300.00	850,559,482.20	2,318,343,817.80	26.8
Бусад урсгал шилжүүлэг	3,168,903,300.00	850,559,482.20	2,318,343,817.80	26.8
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	3,060,058,400.00	741,714,582.20	2,318,343,817.80	24.2
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	103,844,900.00	103,844,900.00	-	100.0
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,000,000.00	5,000,000.00	-	100.0
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	-	(179,712,640.00)	179,712,640.00	
АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	(179,712,640.00)	179,712,640.00	
Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-	(179,712,640.00)	179,712,640.00	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	179,712,640.00	(179,712,640.00)	
<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>				
БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100.0
Төсвийн байгууллага	1	1	-	100.0
АЖИЛЛАГСДЫН ТОО	180	178	-	98.9
Удирдах ажилтан	20	20	-	100.0
Гүйцэтгэх ажилтан	134	132	-	98.5
Үйлчлэх ажилтан	26	26	-	100.0

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

*/төгрөгөөр/*

Дансны код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН		77,833,292.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		77,833,292.00
122	Тусламжийн орлого		77,833,292.00
1221	Хандив тусламж /дотоод/		77,833,292.00
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого		77,833,292.00
350011	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		58,566,876.00
350013	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		19,266,416.00
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		77,833,292.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		77,833,292.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		45,500,000.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		1,090,000.00
210101	Үндсэн цалин		1,090,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал		4,000,000.00
210404	Ном, хэвлэл		4,000,000.00
2107	Томилолт, зочны зардал		17,535,885.00
210702	Дотоод албан томилолт		17,535,885.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		22,874,115.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		22,874,115.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		32,333,292.00
2132	Бусад урсгал шилжүүлэг		32,333,292.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		32,333,292.00

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Ашигт малтмал, газрын тосны газар нь эрхэм зорилгоо “Монгол орны хэмжээнд төрөөс геологи, уул уурхай, газрын тосны салбарын хөгжлийн бодлого боловсруулахад дэмжлэг үзүүлэх, хөрөнгө оруулагч, хэрэглэгчдэд хөнгөн шуурхай, шударга үйлчилгээ үзүүлэх, тус салбарт явуулж буй төрийн бодлогыг хэрэгжүүлэх замаар үндэсний эдийн засгийн хөгжилд ашигт малтмал, газрын тосны салбарын гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэхэд оршино” гэж тодорхойлсон байна.

Ашигт малтмал, газрын тосны газар нь дараах үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлтэй ажиллаж байна. Тухайлбал:

- Төрөөс ашигт малтмал, газрын тосны салбарыг хөгжүүлэх талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх замаар улс орны эдийн засгийн хөгжилд тус салбарын гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд ашигт малтмал, газрын тосны эрэл, хайгуулын ажлыг эрчимжүүлж нөөцийг өсгөх, ордыг ашиглалтад шилжүүлэх, ашигт малтмал, газрын тосны олборлолтыг нэмэгдүүлэх;
- Газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл, хангамжийн тогтвортой байдлыг хадгалах, чанар, стандартын шаардлагад нийцсэн бүтээгдэхүүнээр хэрэглэгчдийг хангах талаарх төрийн бодлогыг хэрэгжүүлэх замаар тус салбарын улс орны нийгэм, эдийн засгийн хөгжилд оруулах хувь нэмрийг нэмэгдүүлэх;
- Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарт хөрөнгө оруулалтын таатай орчин бүрдүүлэх, Уул уурхайн бүтээгдэхүүний эрэлт хэрэгцээг судалж, хэтийн төлөвийг тодорхойлох, ашигт малтмалыг эдийн засгийн өндөр үр ашигтай, байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатай техник, технологи ашиглан олборлох, баяжуулах, гүн боловсруулах, борлуулахтай холбогдсон судалгаа хийж дүгнэлт гаргах, санал зөвлөмж боловсруулах, тэдгээрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, ашигт малтмал олборлох, боловсруулах үйлдвэрлэлийн салбарын хөгжлийн бодлого боловсруулахад дэмжлэг үзүүлэх;
- Ашигт малтмалын тухай хууль, Цөмийн энергийн тухай хууль, Газрын тосны тухай хуулийг хэрэгжүүлэх зорилгоор ердийн болон цацраг идэвхт ашигт малтмалын хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрөл, газрын тосны эрэл, хайгуулын болон гэрээт талбайд холбогдох үйлчилгээ үзүүлэх.

#### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Ашигт малтмалын тухай хууль, Газрын тосны тухай хууль, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль, Газрын тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон холбогдох дүрэм, журмуудыг мөрдлөг болгон ажиллаж байна.

Тайлант хугацаанд тус газрын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна.

- Төсвийн тухай хуульд 2025 онд орсон нэмэлт, өөрчлөлтүүд нь төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, хяналт, хариуцлагын тогтолцоог чангатгаж, төсвийн сахилга бат, дунд хугацааны тогтвортой байдлыг хангахад чиглэсэн байна. Тухайлбал: төсвийг зохисгүй удирдсанаас авлага, өглөг үүсгэсэн төсвийн захирагчид хариуцлага тооцох эрх зүйн үндсийг тодорхой болгож, дунд хугацааны төсвийн мэдээлэлд хараат бус хяналтыг нэмэгдүүлсэн, мөн төсвийн

баримт бичгийн хугацааг богиносгон зохион байгуулалтын сахилга батыг сайжруулсан. Түүнчлэн Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүний өөрчлөлтөөс үл хамааран төсвийн бодлогын залгамж чанарыг хадгалах, эрх мэдлийн давхардлыг арилгах зохицуулалтыг тусгаснаар төсвийн эрсдэлийг бууруулж, санхүүгийн удирдлагын хяналтын орчныг бэхжүүлсэн байх;

- Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2024 онд орсон нэмэлт, өөрчлөлтүүд нь төрийн байгууллагын үйл ажиллагааны зардлыг хязгаарлах, хэмнэлтийг бодитоор хэрэгжүүлэхэд чиглэсэн. Үүнд, зөвлөл, хороо, ажлын хэсгийн гишүүдэд нэмэлт хөлс, урамшуулал олгохыг хориглож, байгууллагын төсвөөр уралдаан, арга хэмжээ зохион байгуулах, семинар, хурал, томилолттой холбоотой зардлыг бууруулах, мөн албан бичгийг цахим хэлбэрээр боловсруулах замаар бичиг хэргийн болон шуудангийн зардлыг хэмнэх зохицуулалтыг хуульчилсан байх;
- Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд 2025 онд орсон нэмэлт, өөрчлөлтүүд нь дунд хугацааны төсвийн хүрээ, нэгдсэн төсвийн тэнцвэржилт, төсвийн тодотголын зохицуулалтыг бодит нөхцөлд нийцүүлэн уян хатан болгох, Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүний өөрчлөлтөөс шалтгаалан төсвийн тогтвортой байдлын шалгуур зөрчигдөх эрсдэлийг бууруулахад чиглэсэн. Мөн төсвийн тогтвортой байдлын үзүүлэлт, тайлагналтай холбоотой зарим давхардсан заалтыг цэгцэлж, эрх зүйн зохицуулалтыг оновчтой болгосон байх;

Удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас аудитад хамааралтай хяналтыг төлөвлөлтийн үе шатанд авч үзэн, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсэн дүн шинжилгээний үр дүнд дотоод хяналтын тогтолцооны зохион байгуулалт, хэрэгжилт нь үр нөлөөтэй байна гэж үнэлэгдлээ.

Мөн Ашигт малтмал, газрын тосны газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн чиг үүрэг, хэрэгжүүлсэн ажлын талаар хангалттай ойлголт олж авсны үндсэн дээр дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, шаардлагатай тохиолдолд дотоод аудитораас шууд туслалцаа авах боломжтой гэж үзсэн.

Тус хэлтэс нь хяналт-шинжилгээ, үнэлгээ болон дотоод аудит хийх, статистик мэдээлэл боловсруулах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлж, хууль тогтоомж, бодлогын баримт бичиг, удирдлагын шийдвэр, дүрэм журмын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх, байгууллагын үйл ажиллагааны үр ашиг, үр нөлөөг дээшлүүлэх, удирдах дээд байгууллага болон олон нийтийг шаардлагатай мэдээллээр хангах ажлыг гүйцэтгэж байна.

Тайлант онд санхүүгийн үйл ажиллагаанд эрсдэлд суурилсан хэсэгчилсэн аудит хийх, бодлогын баримт бичгийн хэрэгжилт, үр дүнг үнэлэх, худалдан авах ажиллагаа болон Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгах ажлыг нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган, төлөвлөсөн ажлуудыг хэрэгжүүлсэн байна.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Ашигт малтмал, газрын тосны газар нь 2019 онд Хүлэгтхүннү Аудит ХХК-ийн боловсруулсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт улсын төсвийн орлогын бүртгэлийг мөнгөн сууриар хөтлөхөөр тусгасан бөгөөд улсын төсвийн орлого ногдуулалт, гадаад болон дотоодын сургалтыг аккруэль сууриар бүртгэх, үе шатны хяналтуудыг хэрэгжүүлэх талаар тусгаагүй байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Ашигт малтмал, газрын тосны газар нь 2025 оны санхүүгийн тайланг хүчингүй болсон Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэн Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.

Тайлант онд Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ыг шинэчлэн баталснаар төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын нэгдмэл, стандартчилагдсан хэрэгжилтийг хангах эрх зүйн шинэ орчин бүрдсэн.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,071,237.5 мянган төгрөгөөр буюу 2.8 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

*/мянган төгрөгөөр/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	179,712.6	-	(179,712.6)
Авлага	8,113,797.4	9,252,835.6	1,139,038.2
Урьдчилгаа	408,396.0	48,670.5	(359,725.5)
Бараа материал	660,855.3	664,143.9	3,288.6
Нөөцийн бараа	23,175,390.3	23,175,390.3	-
Үндсэн хөрөнгө	5,085,628.5	5,553,977.3	468,348.8
<b>Нийт хөрөнгө</b>	<b>37,623,780.1</b>	<b>38,695,017.6</b>	<b>1,071,237.5</b>
Өр төлбөр	179,812.6	1,256,034.5	1,076,221.9
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	37,443,967.5	37,438,983.1	(4,984.4)
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>37,623,780.1</b>	<b>38,695,017.6</b>	<b>1,071,237.5</b>

Оны эхний үлдэгдэлтэй харьцуулахад авлага, үндсэн хөрөнгө, өр төлбөрийн дансуудын үлдэгдэлд материаллаг өсөлт гарсан байна.

Байгууллагаас авах авлагын өмнөх оны үлдэгдэл 8,113,797.4 мянган төгрөгийн 99.9 хувь буюу 8,109,827.4 мянган төгрөг нь газрын тосны хайгуулын үйл ажиллагаа явуулахаар бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулсан 9 гэрээлэгч компанитай холбоотой байна.

Эдгээр гэрээлэгч компаниуд нь орон нутгийн эсэргүүцэл, хөрөнгө оруулалтын эх үүсвэрийн хомсдол, дэлхийн зах зээл дээрх газрын тосны үнийн уналт, хууль эрх зүйн тогтворгүй байдал, шүүхийн маргаан зэрэг гадаад, дотоод хүчин зүйлсийн нөлөөгөөр үйл ажиллагаа явуулаагүй, төлбөр, хураамжаа төлөөгүй нөхцөл байдал 2025 онд үргэлжилсэн байна.

Мөн байгууллагаас авах авлагын үлдэгдэл өссөн нь сонгон шалгаруулалтад шалгараагүй байгууллагуудын журмын дагуу төвлөрүүлсэн, буцаан олгох 1,133,122.6 мянган төгрөгийн “сонгон шалгаруулалтын босго үнэ”-ийг төсөвт төвлөрүүлж, Сангийн яамнаас авах татаас санхүүжилтийн авлагаар тайлагнаснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл өсөхөд дараах орлогын гүйлгээнүүд голлон нөлөөлсөн байна. Үүнд:

- Байгууллагын батлагдсан төсөв болон төлөөлөгчийн газрын үйл ажиллагааг дэмжих хөрөнгийн эх үүсвэрээс 85,101.7 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 1,430.0 мянган төгрөгийн тавилга, эд хогшил, 19,500.0 мянган төгрөгийн программ хангамж худалдан авсан;
- АМГТГ/20250102025 дугаар бүхий тендерийн дагуу 370,000.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл худалдан авсан;
- Монгол Улс, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжүүлж буй “Монгол Улсын эрдэс баялгийн салбарын институцийн болон боловсон хүчний чадавхыг бэхжүүлэх-2” төслийн санхүүжилтээр 152,776.0 мянган төгрөгийн үнэ бүхий 12 ширхэг тоног төхөөрөмжийг үнэ төлбөргүйгээр хүлээн авсан;
- Эрлийн ажил гүйцэтгэх гэрээний 3.4.10-д заасан нөхцөлийн дагуу аж ахуйн нэгжүүдээс нийт 307,200.0 мянган төгрөгийн өртөг бүхий 3 ширхэг автомашиныг үнэ төлбөргүйгээр хүлээн авсан байна. Үүнд, “Жэйд Газ Монголиа” ХХК-аас 91,000.0 мянган төгрөгийн JMC Grand Avenue, “Си Эй Би Ти” ХХК-аас 150,200.0 мянган төгрөгийн Toyota Land Cruiser 70LC 76, “Ууганбулаг” ХХК-аас 66,000.0 мянган төгрөгийн Toyota Corolla Levin маркийн машинууд тус тус хамаарна.

Тайлант хугацаанд тусгай зөвшөөрлийн сонгон шалгаруулалтын босго үнийн буцаалттай холбоотойгоор байгууллагад өгөх өглөг 953,410.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь өглөгийн нийт өсөлтөд нөлөөлсөн байна.

### **3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 10,585,725.9 мянган төгрөг, өөрийн орлогоос 5,426,954.4 мянган төгрөгийг төвлөрүүлж, нийт зарлагыг 16,012,680.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналд тусгагдсан зардлыг 2,043,715.1 мянган төгрөгөөр бууруулж, нийт 13,968,965.1 мянган төгрөгөөр баталсан байна. Үүнээс цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэл, байр ашиглалт, хангамжийн материал, норматив зардал, эд хогшил, урсгал засвар, томилолт, бараа үйлчилгээний зардал болон урсгал шилжүүлгийг нийт 3,975,726.3 мянган төгрөгөөр танасан бол бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 1,932,011.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдөр батлагдсантай холбогдуулан бараа, ажил, үйлчилгээний зардлыг 579,936.5 мянган төгрөгөөр бууруулж, урсгал шилжүүлгийг 274.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, нийт зардлыг 13,389,302.7 мянган төгрөгөөр баталсан байна.

#### **3.5.2 Төсвийн гүйцэтгэл**

Төсвийн захирагч нь “Олборлолт, уул уурхай” /70905/ хөтөлбөрийн хүрээнд 9 арга хэмжээг санхүүжүүлэхээр батлагдсан төсвийн дагуу улсын төсвөөс 7,488,981.3 мянган төгрөгийн санхүүжилт авсан байна. Мөн сургалтын урамшууллын орлогоос 1,746,203.2 мянган төгрөг, төлөөлөгчийг дэмжих сангийн хөрөнгөөс 2,219,118.5 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдлийн 179,712.6 мянган төгрөгийг санхүүжилтийн эх үүсвэрт ашигласан байна.

Дээрх эх үүсвэрүүдээс нийт 9,472,661.4 мянган төгрөгийг зарцуулж, тайлант хугацааны эцэст үүссэн 2,161,354.2 мянган төгрөгийн зарцуулаагүй үлдэгдлийг холбогдох журмын дагуу улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 9,472,661.4 мянган төгрөг буюу 70.7 хувьтай гарсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор Засгийн газраас хэрэгжүүлсэн зардлын хязгаарлалтын арга хэмжээний хүрээнд Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж дансны 1,185,789.1 мянган төгрөгийн санхүүжилтийн зарцуулах эрхийг нээгээгүйтэй холбоотой.

Мөн сургалтын урамшууллын хөрөнгийг зарцуулах журмын шинэчлэл болон сүүлийн таван жил сонгон шалгаруулалт зохион байгуулаагүй нөхцөл байдлын улмаас сургалтын төлбөрийн зардал 2,318,343.8 мянган төгрөгөөр дутуу гүйцэтгэлтэй байгаа нь нийт зардлын гүйцэтгэлд нөлөөлсөн байна.

**Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл**

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт /хувиар/
1	Үндсэн үйл ажиллагааны зардал	7,242,696.2	6,839,448.9	(403,247.3)	94.4%
2	Мэдээлэл, сурталчилгааны зардал	31,533.2	26,894.1	(4,639.1)	85.3%
3	Харуул, хамгаалалтын зардал	77,557.6	70,949.0	(6,608.6)	91.5%
4	Зөвлөл, хороо, комиссын гишүүд	444,016.9	323,877.2	(120,139.7)	72.9%
5	Байр ашиглалтын үйлчилгээ	2,630.7	0.0	(2,630.7)	0.0%
6	Лабораторийн итгэмжлэл	10,000.0	0.0	(10,000.0)	0.0%
7	Ажил олгогчоос олгох тэтгэмж,	153,913.7	149,291.7	(4,622.0)	97.0%
8	Сургалтын төлбөрийн буцалтгүй	3,060,058.4	741,714.6	(2,318,343.8)	24.2%
9	Төлөөлөгчийн газрыг дэмжих үйл ажиллагаа	2,366,896.0	1,320,485.8	(1,046,410.2)	55.8%
	Нийт дүн	13,389,302.7	9,472,661.4	(3,916,641.3)	70.7%

Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан “Төрийн аудитын байгууллагаас төсвийн тухай хуулийн дагуу 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах чиглэл”-ийн дагуу шалгагдагч байгууллагаас судалгаа авч, үр дүнг тусгалаа. Үүнд:

**1. Байгууллагын орон тооны цомхотголын талаар**

Ашигт малтмал, газрын тосны газрын 2025 оны батлагдсан төсөвт орон тоог 200 нэгжээр, цалингийн зардлын санг 6,498,549.4 мянган төгрөгөөр тусгасан байна.

Төсвийн тодотголоор орон тоог 180 нэгж болгон 20 нэгжээр (10 хувь) бууруулж, цалингийн зардлын санг 6,071,444.4 мянган төгрөгөөр баталсан бөгөөд цалингийн сан 427,105.0 мянган төгрөгөөр буурсан байна.

Батлагдсан төсвийн өөрчлөлттэй уялдуулан Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2025 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн А/205 дугаар тушаалаар Ашигт малтмал, газрын тосны газрын бүтэц, зохион байгуулалтыг шинэчлэн баталж, Бүтцийн ерөнхий бүдүүвч, үйл ажиллагааны стратеги болон зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг шинэчлэн хэрэгжүүлсэн байна. Энэхүү шийдвэрийн хүрээнд орон тоог 20 нэгжээр буюу 10 хувиар цомхотгож, байгууллагын бүтэц, чиг үүргийг төсвийн боломжид нийцүүлэн өөрчилсөн байна.

Тайлант жилийн гүйцэтгэлээр цалингийн зардал 5,830,279.4 мянган төгрөгт хүрч, тодотголоор батлагдсан сангаас 242,022.4 мянган төгрөгөөр хэмнэж зарцуулсан байна.

Мөн Засгийн газрын 238 дугаар тогтоолын хавсралтаар төрийн албан хаагчдын албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн баталсан бөгөөд уг зохицуулалт нь 2025 оны цалингийн зардлын төлөвлөлт, гүйцэтгэлд нөлөөлөх суурь эрх зүйн орчныг бүрдүүлсэн байна.

## **2. Унаа, хоолны хөнгөлөлтийн зардлын тарифын талаар**

Ашигт малтмал, газрын тосны газрын даргын 2025 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн Б/63 дугаар тушаалаар ажилтнуудад олгох хоол, унааны хөнгөлөлтийн хэмжээг баталж, нэг ажилтанд ногдох хоолны хөнгөлөлтийг 32,000 төгрөг, унааны хөнгөлөлтийг 3,000 төгрөгөөр тогтоосон байна.

Тайлант онд хоол, унааны хөнгөлөлтийн зардалд 899,718.4 мянган төгрөгийн төсөв батлагдсан бөгөөд тайлант хугацаанд 868,417.2 мянган төгрөгийн гүйцэтгэл гарч, 31,301.2 мянган төгрөгийг дутуу зарцуулсан байна.

Хоол, унааны хөнгөлөлтийн зардлыг батлагдсан тарифын дагуу санхүүжүүлсэн боловч бодит гүйцэтгэл нь орон тооны ашиглалт, ажилтны бодит ирц, сул орон тоо, чөлөөтэй байсан хугацаа зэрэг хүчин зүйлсээс шалтгаалан батлагдсан дүнгээс бага гарч, тодорхой хэмжээний төсвийн хэмнэлт бий болсон байна.

## **3. Гадаад томилолт, арга хэмжээний талаар**

Тус байгууллагын гадаад томилолтын зардал нь Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж дансны ангиллаар төлөвлөгдөж Сургалтын урамшууллын болон Төлөөлөгчийн газрыг дэмжих үйл ажиллагааны хөтөлбөрөөс санхүүждэг.

Гадаад томилолт, арга хэмжээний зардал 2024 оны гүйцэтгэлээр 77,857.4 мянган төгрөг байсан бол 2025 онд 137,307.0 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй байна. Ингэснээр өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулахад 59,449.6 мянган төгрөгөөр буюу 76.3 хувиар өссөн байна.

Гадаад томилолтын хүрээнд Канад, Австрали, БНХАУ болон БНСУ-ын холбогдох байгууллагуудтай уулзаж, эрдэс баялгийн салбарын бодлого, олборлолт-ашиглалтын нөхцөл байдал, хууль эрх зүйн зохицуулалт, технологийн туршлагыг судлан хамтын ажиллагааны боломжийг хэлэлцсэн байна. Үүнээс:

- Канад улсад PDAC 2025 олон улсын чуулганд оролцож, хөрөнгө оруулалтын орчин, уул уурхайн салбарын бодлого болон Онтарио мужийн эрх зүйн зохицуулалтын туршлагаар мэдээлэл солилцсон;
- Австрали улсад IMARC Уул уурхай, эрдэс баялгийн чуулга уулзалтад оролцож, хэлэлцүүлэгт илтгэл тавих, мөн уул уурхай, эрдэс баялгийн салбар дахь төрийн бодлого, хууль эрх зүйн орчин болон холбогдох бусад мэдээллийг гадаадын хөрөнгө оруулагчдад танилцуулсан;
- БНХАУ-д CNPC, SINOPEC болон Дайчин ойлфийлд зэрэг байгууллагуудтай бүтээгдэхүүн хуваах гэрээт талбайн олборлолт, ашиглалтын тулгамдсан асуудлыг хэлэлцэж, Шандун мужид Доншен газрын тос (Монгол) ХХК-ийн 2025 оны ажлын төлөвлөгөө, төсөв, гүйцэтгэгчтэй хийх хэлэлцээнд оролцон, газрын тос олборлолт болон боловсруулах үйлдвэрийн технологийн үйл ажиллагаатай танилцсан. Мөн нүүрсний давхаргын метан хийн үйлдвэрлэлийн бүс нутагт үйлдвэрлэлийн технологи, үйл ажиллагааны зохион байгуулалтыг судалсан;
- БНСУ-д хийн түлшний сургалт болон холбогдох хууль эрх зүйн орчны шинэчлэлийн асуудлыг хэлэлцэж, хийн аюулгүй байдлын зохицуулалт, эрчим хүчний эх үүсвэрийн чанарын хяналтын тогтолцоог сайжруулах чиглэлээр хэрэгжүүлж буй төсөл, хамтын ажиллагааны явц болон цаашдын арга хэмжээг тус улсын холбогдох байгууллагуудтай ярилцсан.

#### **4. Сургалт, семинар, хурал, зөвлөгөөний талаар**

Тайлант онд нийт 16 төрлийн сургалт, хурал, семинар зохион байгуулж, давхардсан тоогоор 461 албан хаагч хамрагдсан байна. Сургалтын гол чиглэл нь үндэсний бичиг, төрийн худалдан авах ажиллагаа, мэдээллийн аюулгүй байдал, ёс зүй, хувь хүний хөгжил, орон нутгийн төлөөллийн чадавхжуулалт зэрэг өргөн хүрээг хамарчээ.

Мөн тайлант хугацаанд Удирдлагын академийн багц сургалтад 30 албан хаагчийг 78,115.0 мянган төгрөгөөр, Худалдан авах ажиллагааны АЗ сургалтад 35 хүнийг 2,974.0 мянган төгрөгөөр суралцуулсан байна.

Хурал, зөвлөгөөн болон томоохон арга хэмжээний хүрээнд “Хүний эрхийн төлөв байдлын IV илтгэлийн хурал”, “Монголын эдийн засгийн форум 2025”, “Аж үйлдвэр, эрдэс баялгийн улсын албанд зохион байгуулах гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэг”, “Уур амьсгалын өөрчлөлтөд таны оролцоо” зэрэг олон талт арга хэмжээнд ажилтнууд оролцсон байна. Эдгээр нь агентлагийн үйл ажиллагааны онцлог, чиг үүрэгт нийцсэн, байгууллагын чадавхыг нэмэгдүүлэхэд чиглэсэн үр өгөөжтэй үйл ажиллагаа болсон байна.

## 5. Программ хангамжийн бүртгэл, тайлагналын талаар

Ашигт малтмал, газрын тосны газарт тайлант хугацаанд нийт 1,422,445.4 мянган төгрөгийн анхны өртөг бүхий 37 нэр төрлийн **биет бус хөрөнгө** ашиглагдаж байна. Үүнээс 24,800.0 мянган төгрөгийн өртөгтэй 2 цахим хуудас, 290,694.3 мянган төгрөгийн өртөгтэй 13 мэдээллийн систем, 1,007,990.5 мянган төгрөгийн өртөгтэй 16 программ хангамж, 95,660.6 мянган төгрөгийн өртөгтэй 4 лиценз, 3,300.0 мянган төгрөгийн өртөгтэй 1 контент, мөн Алтайн ба Монгол Агнуурын атираат бүсүүдийн геологи, тектоник, металлогенийн зураг 1 ширхэг тус тус бүртгэлтэй байна.

Дээрх биет бус хөрөнгүүд нь бүрэн элэгдэж, анхны өртгөө элэгдлээр нөхсөн боловч үйл ажиллагаанд ашиглагдсаар байна.

Мөн 250,000.0 мянган төгрөгийн өртөг бүхий “Mpetro smart solution” программ нь байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа боловч санхүүгийн тайланд биет бус хөрөнгөөр бүртгэгдээгүй байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төрийн сан дахь Ашигт малтмал, газрын тосны газрын нэмэлт санхүүжилтийн 100900018409 тоот дансанд нийт 77,833.3 мянган төгрөгийн эх үүсвэр төвлөрсөн байна. Үүнээс 45,500.0 мянган төгрөг нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр (UNDP) болон Ашигт малтмал, газрын тосны газар хооронд байгуулсан “Интегра” төслийн хүрээнд тайлант жилд хэрэгжүүлэх үйл ажиллагааны санхүүжилт, 32,333.3 мянган төгрөг нь Өмнөговь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолоор батлагдсан “Нутгийн дэм” хөтөлбөрийн хүрээнд орон нутагт ажиллаж буй албан хаагчдад дамжуулан олгох зориулалттай санхүүжилт байна.

Дээрх эх үүсвэрүүдийг холбогдох эрх зүйн акт, батлагдсан зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.5.4 Улсын төсвийн орлого

Ашигт малтмал, газрын тосны газар нь 2025 онд улсын төсөвт 361,488,041.6 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр төсвийн төслийг тооцон дээд шатны төсөв захирагчид хүргүүлснийг Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд 52,398,471.6 мянган төгрөгөөр бууруулж, УИХ-аас 309,089,570.0 мянган төгрөгөөр баталсан байна.

Улсын төсвийн орлогын гүйцэтгэл 422,532,378.4 мянган төгрөг буюу 136.7 хувийн гүйцэтгэлтэй байна.

## Хүснэгт 3. Улсын төсөвт төвлөрүүлсэн орлогын гүйцэтгэл

/мянган төгрөг/

№	Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Гүйцэтгэл (хувь)
1	Газрын тосны орлого	249,694,540.0	231,865,043.6	(17,829,496.4)	92.9
2	Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр	29,983,950.0	45,776,166.3	15,792,216.3	152.7
3	Өөрийн орлого (Сонгон шалгаруулалт)	25,000,000.0	137,895,940.9	112,895,940.9	551.6
4	Үйлчилгээний орлого /газрын тос/	2,279,110.0	3,780,612.9	1,501,502.9	165.9
5	Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн ордын нөхөн төлбөр	2,131,970.0	3,214,614.7	1,082,644.7	150.8
<b>Нийт дүн</b>		<b>309,089,570.0</b>	<b>422,532,378.4</b>	<b>113,442,808.4</b>	<b>136.7</b>

Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтаар 2025 онд улсын төсөвт 25,000.0 мянган төгрөг төвлөрүүлэхээр баталсан бол жилийн эцсийн байдлаар 137,895,940.9 мянган төгрөг төвлөрүүлж, төлөвлөгөөг 551.6 хувиар давуулан биелүүлсэн байна.

Орлогын энэхүү огцом өсөлтөд сонгон шалгаруулалтыг тогтмол, тасралтгүй зохион байгуулсан, босго үнийг тооцох га талбайн үнэлгээ нэмэгдсэн, мөн оролцогч аж ахуйн нэгжүүдээс харьцангуй өндөр үнийн санал ирүүлсэн зэрэг хүчин зүйлс голлон нөлөөлсөн байна.

Газрын тосны орлого төлөвлөсөн хэмжээнээс 7.1 хувиар буюу 17,829,496.4 мянган төгрөгөөр тасарсан байна. Орлогын энэхүү бууралт нь 2025 онд улсын нийт газрын тосны олборлолтын 94 хувийг бүрдүүлж буй Петрочайна Дачин Тамсаг ХХК-ийн үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд хууль, эрх зүй, дэд бүтэц, нийгмийн орчны шинжтэй хүчин зүйлс зэрэгцэн нөлөөлж, батлагдсан олборлолтын төлөвлөгөө бүрэн хэрэгжээгүйтэй холбоотой байна.

Тухайлбал, Тосон-Уул XIX, Тамсаг XXI талбайн бүтээгдэхүүн хуваах гэрээ болон 2014 онд шинэчлэн батлагдсан Газрын тосны тухай хуулийн зохицуулалтын уялдаа, хэрэгжилтийн хүрээнд үүссэн эрх зүйн тодорхой бус байдал нь хөрөнгө оруулагч талын шийдвэр гаргалтад нөлөөлж, 2025 онд батлагдсан ажлын төлөвлөгөө, төсвийн хүрээнд үйл ажиллагааг бүрэн хэмжээнд хэрэгжүүлэх боломжийг хязгаарласан. Үүний үр дүнд хөрөнгө оруулалтын хэмжээ буурч, зарим төлөвлөсөн ажлууд хойшлогдсон байна.

Үүнээс гадна цахилгаан эрчим хүчний хангамжийн доголдол, салбарын үйл ажиллагаатай холбоотой ташаа мэдээлэл олон нийтэд тархсан зэрэг нийгмийн орчны эрсдэлүүд нь үйлдвэрлэлийн хэвийн горимд сөргөөр нөлөөлсөн.

Иймд орлогын тасралт нь эрх зүйн орчны тогтворгүй байдал, хөрөнгө оруулалтын бууралт, дэд бүтцийн хязгаарлалт болон нийгмийн орчны эрсдэл зэрэг нийлмэл хүчин зүйлс нөлөөлсөн байна.

### **3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл**

Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2025 оны А/43 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар Ашигт малтмал, газрын тосны газрын 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг баталсан байна. Уг төлөвлөгөөнд урсгал төсвийн 183,510.1 мянган төгрөг, төлөөлөгчийн газрын үйл ажиллагааны дэмжлэгийн хөрөнгийн 1,029,500.0 мянган төгрөг, нийт 1,213,010.1 мянган төгрөгийн санхүүжилтээр 29 нэр төрлийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авахаар тусгаж, 92 хувийн хэрэгжилттэй гүйцэтгэсэн байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Ашигт малтмал, газрын тосны газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн Ашигт малтмал, газрын тосны газар түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах зорилгоор засаглал, дотоод хяналтын тогтолцоо, хүний нөөцийн удирдлага, мэдээллийн аюулгүй байдал, санхүүгийн бүртгэл ба тайлагнал, төсвийн сахилга бат, хөрөнгө болон бараа материалын бүртгэл, үнэлгээ, улсын төсвийн орлого төвлөрүүлэлттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор А.Даваадорж гүйцэтгэж, аудитын үе шатны чанарын хяналтыг аудитын менежер Д.Энхдалай, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Ашигт малтмал, газрын тосны газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 01/454 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлыг тооцох эх сурвалжийг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар, суурь үзүүлэлтийг нийт зардлын дүнгээс сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэлсэн.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүн 334,942,024.9 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 3,349,420.2 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хуулиар төсвийн байгууллага, түүний албан тушаалтны зарим үйл ажиллагаа, хангамжийг хязгаарласантай холбогдуулан хуулиар хориглосон гар утасны зардал, хэвлэл захиалгын төлбөр, зочин төлөөлөгч хүлээн авах, цахим худалдан авалт арга хэмжээг тайлант онд санхүүжүүлээгүй бөгөөд төсөвт ном хэвлэл, хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгалын зардал батлагдаагүй байна.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Ашигт малтмал, газрын тосны газрын үйл ажиллагаанд хийсэн нийцлийн шалгалтаар стратеги, бодлогын баримт бичиг болон Засгийн газрын тогтоол, шийдвэрийн хэрэгжилт, салбарын чиг үүргийн биелэлт, мэдээллийн аюулгүй байдлын удирдлага, хүний нөөцийн бодлого, хөдөлмөрийн харилцаа, цалин хөлсний зохицуулалт, нягтлан бодох бүртгэлийн хэрэгжилтийн хүрээнд холбогдох хууль тогтоомж, журам, дотоод зохицуулалтын шаардлагыг бүрэн хангаагүй зөрчил, дутагдал тогтоогдлоо.

Тодруулбал, бодлогын зарим арга хэмжээ зорилтот түвшинд хүрээгүй, шатахууны хангамжийн тогтвортой байдлыг хангах чиг үүргийн хэрэгжилт хангалтгүй, мэдээллийн аюулгүй байдлын дотоод хяналт сул, төрийн болон хөдөлмөрийн харилцааны эрх зүйн зохицуулалтыг бүрэн мөрдөөгүй, томилгоо болон гэрээний хэлбэрийг хуульд нийцүүлээгүй, нэмэгдэл хөлсний шийдвэрийг хугацаанд гаргаагүй, бараа материалын бүртгэл, хөрөнгө актлах үйл ажиллагаа журамд нийцээгүй зэрэг 13 зөрчил илэрсэн байна. Эдгээр нь байгууллагын хууль, эрх зүйн нийцэл, дотоод хяналт, удирдлагын хариуцлагын тогтолцоонд эрсдэл үүсгэж байгаа тул зөрчлийг арилгах, таслан зогсоох, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах чиглэлээр нийт 6 зөвлөмж өгч байна.

#### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Ашигт малтмал, газрын тосны газар нь тайлант онд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулбал зохих 21 нэр төрлийн 159 мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Илрүүлэлт 1: Стратеги, бодлогын баримт бичиг, Засгийн газрын шийдвэрүүдийн хэрэгжилт дунджаар 77–89 хувийн биелэлттэй үнэлэгдсэн (Эх сурвалж: ХШҮДА-ын тайлан) боловч уул уурхайн салбарын хариуцлагатай хөгжил, нөхөн сэргээлт, ордын ашиглалтын гэрээ, газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн тогтвортой байдлын чиглэлээр зорилтот үр дүнд бүрэн хүрээгүй, зарим арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй түвшинд байна. Тодруулбал:

- “Алсын хараа–2050” урт хугацааны бодлогын баримт бичгийн хүрээнд уул уурхайн салбарын хариуцлагатай хөгжил, нөхөн сэргээлт, ордын ашиглалтын гэрээний хэрэгжилт зэрэг 4 арга хэмжээний хэрэгжилт дунджаар 77.5 хувьтай үнэлэгдэж, “үр дүн хүлээгдэж буй” ангилалд хамаарсан байна. Үүнээс: Байгаль орчны нөхөн сэргээлтийн ажлын биелэлт хангалтгүй, олон улсын стандартыг мөрдөх шаардлагын хэрэгжилт бүрэн хангагдаагүй бөгөөд ордын ашиглалтын гэрээний шинэчилсэн төсөл эцэслэгдээгүй байна;
- “Засгийн газрын 2024–2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан нийт найман арга хэмжээний хэрэгжилт дунджаар 81.8 хувьтай үнэлэгдэж, үүнээс Цагаансуврага зэс-молибденийн ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах төсөл зорилтот түвшинд хүрээгүй 65 хувьтай үнэлэгдсэн байна;

- Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд туссан 10 арга хэмжээний хэрэгжилт дунджаар 77.5 хувийн биелэлттэй үнэлэгдсэн байна. Үүний дотор Рашаант дахь улсын нөөцийн агуулах төслийн хэрэгжилт бүрэн хангагдаагүй 50.0 хувьтай, Цагаансуврага зэс-молибденийн ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах төсөл 65.0 хувьтай үнэлэгдсэн байна;
- 'Шинэ сэргэлтийн бодлого'-д туссан гурван арга хэмжээний хэрэгжилт дунджаар 81.6 хувьтай үнэлэгдсэн байна. Гэвч нөхөн сэргээлтийн ажлын зарим хэсэг 'үр дүн хүлээгдэж буй' ангилалд багтсан бөгөөд техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн биелэлт зорилтот түвшинд хүрээгүй байна. Мөн газрын тосны бүтээгдэхүүний импортын хангамжийн тогтвортой байдалд тодорхой хэмжээний эрсдэл хэвээр байна;
- Ашигт малтмал, газрын тосны газрын үндсэн чиг үүрэгт хамаарах Засгийн газрын 10 тогтоол, 3 тэмдэглэлийн нийт 17 заалтын хэрэгжилт дунджаар 88.8 хувьтай үнэлэгдсэн байна. Гэвч Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн хэрэгжилт 63.3 хувьд хүрсэн бөгөөд зарим заалтын хэрэгжилт хангалтгүй байна. Тухайлбал, бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулах эрх олгосон хэд хэдэн тохиолдолд хэрэгжилтийн хугацаа хоцорч, зарим компани гэрээ байгуулахаас татгалзсан нь тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн үр нөлөөг бууруулсан байна. Мөн Засгийн газрын тогтоолоор олгосон эрхийг хуульд заасан хугацаанд хэрэгжүүлээгүй байна. /жишээ нь 'Петроматад' ХХК-ийн Дарьганга ХХIV талбайн гэрээний хэрэгжилт/;
- Ашигт малтмал, газрын тосны газар нь газрын тосны бүтээгдэхүүний нийлүүлэлт, хангамжийн тогтвортой байдлыг хангах чиг үүргийн зарим хэсгийг бодитой хэрэгжүүлээгүйгээс Аи-92 болон К5 (Евро-5) автобензиний импорт, нөөц бүрдүүлэлт, түгээлтийн төлөвлөлт, зохион байгуулалт, уялдаа хангалтгүй байсан бөгөөд үүний үр дагаварт зах зээлд шатахууны хомсдол үүсэж, иргэдийн шатахуун авах боломж хязгаарлагдан, олон нийтийн дунд бухимдал бий болгосон байна.

Энэ нь Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3-т "Агентлагийн дарга нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 8.3.1. энэ хуулийн 7.1.1-д заасан хууль тогтоомж, зарлиг, шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, явц, биелэлтэд хяналт тавих" гэж заасантай нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Нөхөн сэргээлт, ордын ашиглалтын болон бүтээгдэхүүн хуваах гэрээ, стратегийн төслүүд, шатахууны хангамжийн чиглэлээр зорилтот түвшинд хүрээгүй арга хэмжээнүүдийн саатлын шалтгааныг тогтоож, хариуцагч, хугацаа, хэмжигдэхүйц үр дүнгийн шалгуур бүхий сайжруулах арга хэмжээний төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж, хэрэгжилтэд хариуцлага тооцох механизмыг мөрдүүлэх.

**Илрүүлэлт 2:** Байгууллагын мэдээллийн аюулгүй байдлын хяналтын тогтолцоо хангалтгүй байгаа нь мэдээллийн системийн найдвартай ажиллагаа, өгөгдлийн хамгаалалт, санхүүгийн мэдээллийн үнэн зөв байдалд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байна. Тодруулбал:

- Байгууллагын мэдээллийн аюулгүй байдлын бодлого, журам болон холбогдох хууль, эрх зүйн актуудыг бүх албан хаагчдад танилцуулах, хэрэгжилтийг хянах, дотоод хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоо бүрдүүлэх үйл ажиллагаа хангалтгүй байна. Мэдээллийн аюулгүй байдлын асуудал хариуцсан нэгж, албан тушаалтан томилоогүй бөгөөд хэрэгжилтийн хяналт, тайлагнал тогтмол хийгдээгүй байна.
- Сервер болон мэдээллийн бааз доголдсон үед үйл ажиллагааг тасралтгүй үргэлжлүүлэх сэргээн босголтын нөөц систем, төлөвлөгөө боловсруулаагүй,

баталгаажуулсан баримт бичиггүй байна. Мөн кибер халдлагын үед авах хариу арга хэмжээний төлөвлөгөө (Incident Response Plan) батлагдаагүй бөгөөд туршилт, сорилт хийгдээгүй байна.

- Санхүүгийн болон бусад мэдээллийн системд нэвтрэх эрхийн хяналт сул, хэрэглэгчийн эрхийн түвшинг тодорхойлсон журам бүрэн мөрдөгдөөгүй байна. Хэрэглэгчийн үйлдлийн лог бүртгэл хангалтгүй, систем дотор хийгдсэн бүх үйлдэл, өөрчлөлт, гүйлгээг цаг хугацааны дарааллаар бүртгэж хадгалах зохицуулалт бүрдээгүй байна.

Энэ нь Засгийн газрын 2023 оны 224 дүгээр тогтоолоор баталсан "Кибер аюулгүй байдлыг хангах нийтлэг журам"-ын 1.2, 2.1.2, 4.16, 4.17, 7.1 заалттай нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Мэдээллийн аюулгүй байдлын хариуцлагыг байгууллагын одоогийн бүтэц, орон тооны хүрээнд тодорхой хуваарилж, эрх, үүргийг албан тушаалын тодорхойлолтод тусган баталгаажуулах, мэдээллийн системийн тасралтгүй ажиллагаа болон кибер халдлагын үеийн хариу арга хэмжээний төлөвлөгөөг баталж хэрэгжүүлэх, нэвтрэх эрхийн хяналт болон хэрэглэгчийн үйлдлийн бүртгэлийг журамлан мөрдүүлж, хэрэгжилтэд тогтмол хяналт тавих.

**Илрүүлэлт 3:** Ашигт малтмал, газрын тосны газрын дарга нь байгууллагын үйл ажиллагаанд шаардагдах зарим албан тушаалын чиг үүргийг гүйцэтгүүлэхдээ Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу хөдөлмөрийн гэрээ байгуулаагүй, Иргэний хуулийн дагуу ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан байна.

Тухайлбал, үйлчлэгч, цэвэрлэгч, архивч, бичиг хэргийн ажилтан, орон нутгийн төлөөлөгч, жолооч зэрэг байнгын шинжтэй, байгууллагын үндсэн үйл ажиллагаанд хамаарах ажлын үүргийг ажил гүйцэтгэх гэрээний хэлбэрээр гүйцэтгүүлж, эдгээр ажилтнуудад сар бүр төрийн үйлчилгээ (ТҮ) болон төсвийн захирагчийн (ТЗ) зэрэглэлээр цалин, урамшуулал тооцож олгож байгаа нь хууль тогтоомжийн шаардлагыг зөрчсөн байна.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.3-т "Ажил олгогч, ажилтны хоорондын харилцаа нь энэ хуулийн 4.1.15-д заасан хөдөлмөр эрхлэлтийн харилцааны шинжтэй бол хөдөлмөрийн гэрээнээс өөр төрлийн гэрээ байгуулахыг хориглоно...", Засгийн газрын 2003 оны 233 дугаар тогтоолын хавсралтын 4.1.1-т "Цөөн хүнтэй байгууллагын хувьд үйл ажиллагаа, байршлыг ойр байх нөхцөлийг харгалзан багийг 10-аас доошгүй ажилчидтай байхаар зохион байгуулах боломжийг судлан хэрэгжүүлэх, Хамтран баг байгуулан ажиллуулах боломжгүй хэт цөөн ажилчидтай байгууллагууд ажил, үйлчилгээг гэрээт ажилтан буюу хувь хүмүүстэй гэрээ байгуулан гүйцэтгүүлж болно.", 6.1-т "Гэрээгээр гүйцэтгэх албан тушаал, .... жолооч /сургууль/, " гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Байгууллагын үндсэн болон байнгын шинжтэй чиг үүргийг гүйцэтгүүлж буй албан тушаалд Иргэний хуулийн дагуу ажил гүйцэтгэх гэрээ байгуулах зохицуулалтыг зогсоож, хөдөлмөрийн харилцааны бодит агуулгад нийцүүлэн Хөдөлмөрийн тухай хууль болон холбогдох төрийн албаны эрх зүйн зохицуулалтын хүрээнд гэрээний хэлбэрийг нийцүүлэн өөрчилж, цалин хөлс, нэмэгдэл, урамшууллыг хуульд нийцүүлэн олгох.

**Илрүүлэлт 4:** Ашигт малтмал, газрын тосны газрын дарга нь Төрийн албаны тухай хуульд заасны дагуу төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгүүлэх тохиолдолд 14 хоногийн дотор шийдвэр гаргаж, холбогдох нэмэгдэл хөлсийг тооцох ёстой боловч энэхүү хугацааг мөрдөөгүй байна. Тухайлбал:

- 2024 оны 06 дугаар сарын 24-ний өдрөөс эхлэн албан үүргийг зэрэгцээ хавсран гүйцэтгэж буй албан хаагчид нэмэгдэл олгох шийдвэрийг 2025 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн Б/05 дугаар тушаалаар,
- 2024 оны 08 дугаар сарын 05-ны өдрөөс эхлэн хавсран гүйцэтгэж буй албан хаагчид нэмэгдэл олгох шийдвэрийг 2025 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн Б/34 дугаар тушаалаар,
- 2024 оны 11 дүгээр сарын 02-ны өдрөөс эхлэн хавсран гүйцэтгэж буй албан хаагчид нэмэгдэл олгох шийдвэрийг 2025 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн Б/103 дугаар тушаалаар,
- 2025 оны 02 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн хавсран гүйцэтгэж буй албан хаагчид нэмэгдэл олгох шийдвэрийг 2025 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн Б/112 дугаар тушаалаар тус тус гаргасан байна.

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1-т "Энэ хуулийн 43.3.1-д зааснаас бусад тохиолдолд төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгүүлэх тухай шийдвэрийг эрх бүхий албан тушаалтан 14 хоногийн дотор гаргана.", 43.3.3-д "энэ хуулийн 43.3.1, 43.3.2-т зааснаас бусад тохиолдолд албан тушаалтны албан үүргийг тухайн төрлийн албан тушаалын чиг үүрэгт нь хамгийн ойр хамааралтай албан хаагчтай тохиролцсоны дагуу түр орлон гүйцэтгүүлэх",

Засгийн газрын 2019 оны 9 дүгээр тогтоолын хавсралтын 2 дугаар зүйлийн 2.4-т "Төрийн албаны тухай хуулийн 3.1.4-т тодорхойлсон сул орон тооны албан үүргийг түр орлон гүйцэтгэх тохиолдолд тухайн албан тушаалын үндсэн цалингийн зөрүүг түр орлон гүйцэтгэсэн хугацаагаар тооцож олгоно. Албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийн үндсэн цалин, сул орон тооны албан тушаалын үндсэн цалинтай адил буюу түүнээс бага байх тохиолдолд энэ журмын 2.2-т заасныг баримтална" гэж заасантай нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Төрийн албаны тухай хуулийн шаардлагыг мөрдөж, албан үүргийг түр орлон гүйцэтгүүлэх тохиолдолд нэмэгдэл хөлсийг тухайн үүргийг гүйцэтгэж эхэлсэн хугацаанаас тооцож, шийдвэрийг хугацаанд нь гарган хэрэгжүүлэх, цаашид холбогдох шийдвэрийг хуульд нийцүүлэн цаг тухайд нь баталгаажуулж, хэрэгжилтэд хяналт тавих.

**Илрүүлэлт 5:** Ашигт малтмал, газрын тосны газрын төрийн захиргааны албан тушаалын үндсэн орон тоонд хамаарах нийт 26 албан тушаалтан нь төрийн албан хаагчийн шалгалт өгч, тангараг өргөөгүй түр томилгоотой, 2 албан хаагчийг тусгай шалгалт явуулалгүйгээр албан тушаалд томилсон байна. /удирдах түвшний 6, гүйцэтгэх түвшний 22/

Тухайлбал: Тус байгууллагын сүүлийн 4 агентлагийн дарга нь албан үүргийг түр орлон гүйцэтгэгч томилгоотой байсан байна.

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.1 дэх заалт, 33 дугаар зүйлийн 33.3 дахь заалт, 36 дугаар зүйлийн 36.1 дэх заалт, 42 дугаар зүйл "Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэх үндэслэл", 43 дугаар зүйл "Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэх журам"-тай нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Төрийн захиргааны албан тушаалд томилгоо хийхдээ Төрийн албаны тухай хуулийн 27, 33, 36, 42, 43 дугаар зүйлд заасан сонгон шалгаруулалт, тангараг өргөх, тусгай шалгалтын журмыг бүрэн мөрдөж, түр орлон гүйцэтгэгчийн томилгоог хуульд заасан үндэслэл, хугацаанд хязгаарлан, сул орон тоог хуульд нийцүүлэн шуурхай нөхөх зохион байгуулалтын арга хэмжээ авах.

**Илрүүлэлт 6:** Албан хаагчидтай байгуулсан хөдөлмөрийн гэрээ болон Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрт заасны дагуу орон нутагт томилолтоор ажил үүргээ гүйцэтгэдэг албан хаагчдад нормын хувцас олгодог боловч байгууллагын Хөдөлмөрийн дотоод журам, НБББББ болон бусад холбогдох журмуудад нормын хувцасны эдэлгээний хугацааг тодорхой заагаагүйгээс ашиглалтын хугацаа дууссан, олон жил болсон хувцас хэрэгслийг акталж данснаас хасах ажиллагаа хийгдээгүй, бараа материалын бүртгэлд үлдэгдэлтэй хэвээр байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-т "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална: 5.1.4.үнэн зөв байх", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах",

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т "Агентлагийн хэмжээнд агентлагийн даргын хууль тогтоомжид нийцүүлэн баталсан хөдөлмөрийн дотоод журмыг мөрдөнө" 10.4-т "Хөдөлмөрийн дотоод журамд дараахь үндсэн зүйлийг тусгана: ..." гэж заасантай нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Нормын хувцасны ашиглалтын хугацаа, эдэлгээний шалгуур, актлах болон данснаас хасах зохицуулалтыг Хөдөлмөрийн дотоод журам болон холбогдох нягтлан бодох бүртгэлийн журамд тодорхой тусган баталгаажуулж, хугацаа дууссан болон ашиглах боломжгүй болсон хувцас хэрэгслийг холбогдох журмын дагуу актлан бүртгэлээс хасах, цаашид олголт, бүртгэл, тайлагналд дотоод хяналтыг хэрэгжүүлэх.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2025 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланг хамруулан, мөнгөн хөрөнгө, цалингийн зардал, бараа материал болон үндсэн хөрөнгийн дансдад аудитын горим, сорилыг хэрэгжүүлсэн.

Шалгалтын үр дүнд нийт 42,563,692.5 мянган төгрөгийн дүн бүхий 29 алдаа, зөрчил илэрсэн бөгөөд эдгээр асуудлын хэрэгжилт, залруулгын байдлыг жилийн эцсийн аудитаар дахин хянан шалгаж, үр дүнг аудитын тайланд тусгасан.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн 20,461.2 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 5,750,176.3 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 7 албан шаардлага хүргүүлэн, 5 асуудлаар зөвлөмж өгсөн ба 76.9 хувийн гүйцэтгэлтэй байна.

*Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт*

Д.д	Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
1	Төлбөрийн акт	1	20,461.2	1	20,461.2	100.0
2	Албан шаардлага	7	5,750,176.3	7	5,750,176.3	100.0
3	Зөвлөмж	5	-	2	-	40.0
	<b>Нийт дүн</b>	13	5,770,637.5	10	5,770,637.5	76.9

Тайлант оны аудитаар бүрэн хэрэгжээгүй доорх 2 зөвлөмжид холбогдуулан албан шаардлага хүргүүлж, суралцагчдын сонгон шалгаруулалттай холбоотой хэрэгжээгүй 1 зөвлөмжийг дээд шатны төсөв захирагчид хүргүүлэхээр шийдвэрлэсэн. Үүнд:

- Ашигт малтмал, газрын тосны газар нь газрын тосны бүтээгдэхүүний импорт, үлдэгдэл, үнэ болон борлуулалтын мэдээ, мэдээллийн mpetro.smartsolution.mn системийг анхан шатны баримт материалд үндэслэн үнэлж бүртгэлд тусгах;
- Үлдэх өртөггүй үндсэн хөрөнгийн ашиглалтын байдлыг үнэлж, ашиглалтын хугацаа, өртгийг бодитой тогтоох талаар зохих байгууллагад хандан шийдвэрлүүлэх.

#### **4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар дараах асуудлуудыг авч үзэх нь зүйтэй байна. Үүнд:

- Газрын тосны тухай хууль, Бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасны дагуу гэрээлэгчээс бүрдүүлж буй сургалтын урамшууллын хөрөнгөөр сургах суралцагчдын сонгон шалгаруулалтыг 2020 оноос өнөөг хүртэл хийгээгүй, тус салбарын мэргэжилтэн, боловсон хүчнийг бэлтгэх нөөц боломжийг алдагдуулсан;
- Ашигт малтмалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.5, 11.1.6, 11.1.7-д тус тус заасан геологи, эрдэс баялгийн мэдээллийн сан бүрдүүлэх, баяжуулах, хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн төлөвлөгөө, тайлан болон хайгуулын ажлын зардлын доод хэмжээнд хяналт тавих, ашигт малтмалын тойм судалгаа хийх хүсэлтийг хүлээн авч бүртгэн шийдвэрлэх чиг үүргийг Ашигт малтмал, газрын тосны газрын геологийн асуудал хариуцсан нэгж хэрэгжүүлж байна.

Гэвч Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг болох Үндэсний геологийн алба нь геологийн чиг үүргийг хэрэгжүүлэн үйл ажиллагаа явуулж байгаа нөхцөлд ижил төстэй чиг үүргийг Ашигт малтмал, газрын тосны газрын бүтцэд давхар хариуцуулсан нь байгууллагуудын чиг үүргийн давхардлыг бий болгож, эрх хэмжээний хуваарилалт, хариуцлагын тогтолцооны зааг тодорхой бус болох, улмаар удирдлага, зохион байгуулалт, хяналт-шинжилгээний үр нөлөө сулрах эрсдэлийг үүсгэж байна.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар УСНББОУС 1-ийн 21, 27, 48-52 дугаар заалтад нийцээгүй нийт 2,117,784.1 мянган төгрөгийн 3 алдаа илэрснээс 2,112,240.9 мянган төгрөгийн 2 алдааг аудитын явцад залруулж, зардал бууруулж бичилт хийсэн 5,543.2 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаанд зөвлөмж өгсөн. Үүнд:

Залруулсан алдаа: Ашигт малтмал, газрын тосны газрын даргын 2026 оны 1/454 дугаар албан бичгээр Үндэсний аудитын газарт ирүүлсэн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд нийт 2,112,240.9 мянган төгрөгийн 2 алдаа илэрснийг аудитын явцад залруулсан. Үүнд:

- Санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгийн дүн нь нийт өр төлбөр болон цэвэр хөрөнгө, өмчийн дүнтэй 29,407.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан;
- Төсвийн гүйцэтгэлийн тайланд улсын төсвийн санхүүжилт болон байгууллагын өөрийн орлогын дүн хоорондоо 2,082,833.9 мянган төгрөгийн зөрүүтэй тайлагнасан.

Залруулаагүй алдаа: Ашигт малтмал, газрын тосны газрын 2025 оны санхүүгийн тайланг бэлтгэхдээ нийт 5,543.2 мянган төгрөгийн зардал бууруулах бичилт хийсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-т "төсвийн орлого, зарлага, хөрөнгө, өр төлбөрийн гүйлгээг бууруулах бичилт хийхгүйгээр нийт дүнгээр нь төлөвлөж, тайлагнах",

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасантай нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Цаашид Төсвийн тухай хуульд нийцүүлэн орлого, зардлыг бодит гүйцэтгэлээр бүртгэж, зардал бууруулах бичилт хийхгүй байх, санхүүгийн тайлан бэлтгэх шатанд урьдчилсан болон дараах хяналтыг хэрэгжүүлж, зардлыг зохиомлоор бууруулан тайлагнах зөрчлийг давтан гаргахгүй байх.

Аудитаар нийт 65,798,336.2 мянган төгрөгийн 15 зөрчил<sup>1</sup> илэрснээс 19,793,271.5 мянган төгрөгийн зөрчилд 8 албан шаардлага хүргүүлж, 46,005,064.7 мянган төгрөгийн зөрчилд 5 зөвлөмж өгсөн.

Аудитаар илэрсэн 65,798,336.2 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон 3,349,420.2 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс их бөгөөд улсын төсвийн орлого бүрдүүлэлттэй холбоотой зөрчлийг шинж чанарын хувьд материаллаг гэж үзэн “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

### 5.1 Албан шаардлага

5.1.1. Ашигт малтмал, газрын тосны газрын даргын 2025 оны А/15 дугаар тушаалаар баталсан “Төлөөлөгчийн газрын үйл ажиллагааг дэмжих хөрөнгийг зарцуулах журам”-д нийцээгүй зорилго, зориулалтаар нийт 417,528.6 мянган төгрөгийн хөрөнгийг зарцуулсан байна. Үүнд:

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

- Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын хэрэгцээнд зориулан Номин моторс ХХК-тай АМГТГ/20250102025 дугаартай “Туулах чадвар сайтай автомашин худалдан авах” гэрээ байгуулж, 370,000.0 мянган төгрөгийн өртөгтэй NISSAN Patrol-Y63 маркийн автомашин худалдан авсан;
- Топика ХХК-тай АМГТГ/20250202030, 2025/129 дугаар бүхий “Нэвтрэх хаалга, удирдлагын систем худалдан авах” гэрээ байгуулж, 28,028.6 мянган төгрөгийн өртөг бүхий хөрөнгө худалдан авсан;
- Чингэлтэй “Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтыг дэмжих төв” ОНӨААТҮГ-тай 2025/132 дугаар бүхий “Ажил гүйцэтгэх” гэрээ байгуулж, Чингэлтэй дүүргийн 4 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах Засгийн газрын 12 дугаар байрны гаднах зам, талбайг тэгшилж цутгах, явган зам засварлах ажилд 19,500.0 мянган төгрөгийг зарцуулсан..

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2.2 "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах" гэж заасантай,

"Төлөөлөгчийн газрын үйл ажиллагааг дэмжих хөрөнгийг зарцуулах журам"-ын 3.1.1-т "Газрын тосны хайгуул, ашиглалт, борлуулалт, тээвэрлэлтийн үйл ажиллагаанд хяналт тавихад шаардлагатай автомашин, зөөврийн орон сууц, техник, тоног төхөөрөмж зэрэг үндсэн хөрөнгийг худалдан авах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: “Төлөөлөгчийн газрын үйл ажиллагааг дэмжих хөрөнгийг зарцуулах журам”-д нийцээгүй зардлыг санхүүжүүлсэн зөрчлийг таслан зогсоож, цаашид уг хөрөнгийг зөвхөн батлагдсан зорилго, зориулалтын хүрээнд зарцуулах эрх зүйн нийцлийг хангах, холбогдох дотоод хяналт болон урьдчилсан хяналтын тогтолцоог боловсронгуй болгож, тогтмол мөрдүүлэх талаар албан шаардлага хүргүүлэх.

5.1.2. Газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээний хүрээнд үүссэн авлагын үлдэгдлээс олон жилийн насжилттай, 9 харилцагчтай холбоотой нийт 8,109,827.4 мянган төгрөгийн авлагыг барагдуулах, шүүхийн болон шүүхийн өмнөх журмаар шаардах, тооцоо нийлж баталгаажуулах, холбогдох хариуцлагын арга хэмжээ авах чиглэлээр байгууллагын үе үеийн удирдлага, хариуцсан албан тушаалтнууд бодитой, үр дүнтэй арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй байна..

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 16.1-т "Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна",

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээний хүрээнд үүссэн олон жилийн насжилттай, хөөн хэлэлцэх хугацаа дууссан авлагыг бодитоор үнэлж, тооцоо нийлэх, баталгаажуулах ажлыг нэн даруй зохион байгуулан, барагдуулах, шүүхийн болон шүүхийн өмнөх журмаар шаардлага тавих, холбогдох хариуцлагын арга

хэмжээ авах ажлыг эрчимжүүлж, цаашид авлагын удирдлага, насжилтын хяналт, баталгаажуулалт, үлдэгдлийн бодит үнэлгээг тогтмол хэрэгжүүлэх талаар албан шаардлага хүргүүлэх.

5.1.3 Засгийн газрын 2025 оны 34 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх хүрээнд Ашигт малтмал, газрын тосны газрын даргын А/86, А/128 дугаар тушаалаар гэрээгээр шатахуун хадгалагч 7 компанид хадгалагдаж байсан зуны дизель түлшний улсын нөөцөөс 5,191.6 тонн түлшийг зах зээлийн үнээр борлуулж, олсон орлогоор ТС-1 онгоцны түлшний улсын нөөц бүрдүүлэх чиг үүргийг “Эрчис-Ойл” ТӨХХК-нд хариуцуулсан байна.

Уг чиглэлийн дагуу “Эрчис-Ойл” ТӨХХК тайлант онд 3,506.8 тонн дизель түлшийг 6 компаниас хүлээн авч 9,821,992.9 мянган төгрөгөөр борлуулсан боловч энэ гүйлгээтэй холбоотой бараа материалын тооцоо, авлага, өглөгийг Ашигт малтмал, газрын тосны газар санхүүгийн тайландаа бүртгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Засгийн газрын 2025 оны 34 дүгээр тогтоолын хэрэгжилтийн хүрээнд шатахуун хадгалж, борлуулсан болон “Эрчис-Ойл” ХХК-д хариуцуулсан дизель, ТС-1 түлштэй холбоотой бараа материал, өглөг, авлагын тооцоог бүрэн хийж, баталгаажуулан, санхүүгийн тайланд бүрэн, үнэн зөв тусгах, холбогдох бүртгэлийн зөрчлийг арилгах талаар албан шаардлага хүргүүлэх.

5.1.4. Сонгон шалгаруулах тендерт шалгараагүй 68 харилцагчид өгөх 1,133,122.6 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэсэн, 55 харилцагчтай тооцоо нийлж баталгаажуулаагүй байна. Мөн Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн А/102 дугаар тушаалаар баталсан “Сонгон шалгаруулалтын журам”-д тендерт шалгараагүй компаниудын босго үнийн төлбөрийг буцаан олгох зохицуулалт тусгагдаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх",

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Тендерт шалгараагүй 68 харилцагчийн 1,133,122.6 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдэлд тооцоо нийлж, баталгаажуулах, “Сонгон шалгаруулалтын журам”-д заасан босго үнийн төлбөрийг буцаан олгох зохицуулалтаар дээд шатны төсвийн захирагчид саналаа хүргүүлж шийдвэрлүүлэх, үүссэн өглөгийг барагдуулах талаар албан шаардлага хүргүүлэх.

5.1.5. Газрын тос болон уламжлалт бус газрын тосны эрлийн гэрээг 2022–2025 онд байгуулсан 6 аж ахуйн нэгж нь гэрээний 3 дугаар зүйлийн 3.4.10-д заасан, “Компани нь энэхүү гэрээний 3.1.3-т заасан Ашигт малтмал, газрын тосны газраас томилогдсон мэргэжилтний ажил үүргээ гүйцэтгэхэд шаардагдах 1 ширхэг автомашин (жийп ангиллын, туулах чадвар сайтай, шинэ, дизель хөдөлгүүртэй)-ыг худалдан авч Ашигт

малтмал, газрын тосны газарт буцалтгүйгээр хүлээлгэн өгөх" үүргээ биелүүлээгүй байна.

Энэ нь Иргэний хуулийн 206 дугаар зүйлийн 206.1-д "Үүргийг тогтоосон газар, хугацаанд нь, зохих ёсоор, шударгаар гүйцэтгэнэ", 208 дугаар зүйлийн 208.1-д "Үүргийг хууль буюу гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэнэ", 211 дүгээр зүйлийн 211.1-д "Үүргийн гүйцэтгэлийг үүрэг гүйцэтгүүлэгчид, эсхүл хууль, гэрээ буюу шүүх, арбитрын шийдвэрт заасан эрх бүхий этгээдэд хүлээлгэж өгнө" гэж заасантай нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Газрын тос болон уламжлалт бус газрын тосны эрлийн гэрээний 3 дугаар зүйлийн 3.4.10-т заасан үүргийн хэрэгжилтийг бүрэн хангуулж, гэрээгээр хүлээсэн автомашиныг Ашигт малтмал, газрын тосны газарт хүлээлгэн өгөх асуудлыг холбогдох аж ахуйн нэгжүүдээр нэн даруй шийдвэрлүүлэн, үүргийн биелэлтэд тогтмол хяналт тавьж, үр дүнг баталгаажуулах арга хэмжээ авах талаар албан шаардлага хүргүүлэх.

5.1.6. Нэг ижил объектод хамаарах (нэг хуулийн төсөл), нэг ижил эцсийн үр дүнтэй (хуулийн төсөлд санал, дүгнэлт боловсруулах), нэг гүйцэтгэгчээр, нэг хугацаанд гүйцэтгэх нийт 36,000.0 мянган төгрөгийн өртөг бүхий ажлыг шууд гэрээ байгуулах зорилгоор төсөвт өртгийг хувааж, Ажиглалт ХХК-тай 2025 оны 09 дүгээр сарын 22-ны өдөр 2025/123, 2025/124 дугаартай "Ажил гүйцэтгэх гэрээ"-г тус тус байгуулан, гэрээ тус бүрийн үнийг 18,000.0 мянган төгрөгөөр тогтоож, ажлыг гүйцэтгүүлсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2-т "Энэ хуулийн 31.2-т зааснаас бусад тохиолдолд нийт төсөвт өртөг нь шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээг захиалагч шууд худалдан авч болно", 10.3-т "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Нэг ижил объект, үр дүнтэй ажлыг хэсэгчлэн хувааж шууд гэрээ байгуулсан зөрчлийг таслан зогсоож, холбогдох гэрээг байгуулах шийдвэр, төсөвт өртгийн тооцоололд дотоод хяналт хэрэгжүүлэх талаар албан шаардлага хүргүүлэх.

5.1.7. Ашигт малтмал, газрын тосны газрын даргын 2025 оны А/249 дүгээр тушаалын дагуу "Бизнес процесс менежмент" ХХК-тай 2025/137, "Актуариал солюшнс" ХХК-тай 2025/136 дугаар бүхий "Зөвлөх үйлчилгээ үзүүлэх" гэрээнүүдийг тус тус байгуулж, гүйцэтгэх ажил, санхүүжилтийг хоёр төсвийн жил дамнуулан хэрэгжүүлэхээр тохиролцон, урьдчилгаа төлбөрт нийт 19,800.0 мянган төгрөгийг шилжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.5-д "Төсвийн захирагч нь энэ хуулийн 43.1.3, 43.1.5-д зааснаас бусад төсвийг хоёр төсвийн жил дамжуулан зарцуулахгүй" гэж заасантай нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Төсвийн хөрөнгийг хоёр төсвийн жил дамнуулан зарцуулсан зөрчлийг таслан зогсоож, гэрээ байгуулах, санхүүжилт олгох шийдвэрт урьдчилсан эрх зүйн болон санхүүгийн хяналтыг хэрэгжүүлэх талаар албан шаардлага хүргүүлэх.

5.1.8. Ашигт малтмал, газрын тосны газар нь Ухаалаг шийдэл ХХК-тай 2019 онд 1931 дугаартай "Эрдэм шинжилгээ, судалгааны ажил гүйцэтгэх зөвлөх үйлчилгээний гэрээ" байгуулж, газрын тосны бүтээгдэхүүний импорт, үлдэгдэл, үнэ болон борлуулалтын мэдээ, мэдээллийг нэгтгэн боловсруулах [mpetro.smartsolution.mn](http://mpetro.smartsolution.mn)

системийг нийт 255,000.0 мянган төгрөгийн өртгөөр хүлээн авч, 2020 оноос ашиглаж эхэлсэн боловч уг системийг биет бус хөрөнгийн бүртгэлд тусгаагүй байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-т "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална: 5.1.2 тасралтгүй байх; 5.1.4 үнэн зөв байх", 6 дугаар зүйлийн 6.1-т "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө", 13 дугаар зүйлийн 13.4-т "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Mpetro.smartsolution.mn системийг биет бус хөрөнгийн бүртгэлд хууль, стандартын дагуу үнэн зөв тусгаж, өмнөх тайлант хугацаанд бүртгээгүй зөрчлийг залруулан, санхүүгийн тайланд зохих ангиллаар бүрэн тусгах талаар албан шаардлага хүргүүлэх.

## **5.2 Зөвлөмж**

### **1. Улсын төсвийн орлоготой холбоотой асуудал**

Илрүүлэлт: Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэн гүйцэтгэсэн хайгуулын ажлын зардлын нөхөн төлбөрийн орлоготой холбоотойгоор 1998–2016 онд тусгай зөвшөөрөл эзэмшсэн 12 эзэмшигчид хамаарах 2,398,398.39 ам.долларын үлдэгдэл (ханш 1 ам.доллар = 3,556.66 төгрөг), мөн 2017–2025 онд тусгай зөвшөөрөл эзэмшсэн 20 эзэмшигчид хамаарах 5,326,216.7 мянган төгрөгийн үлдэгдэл, нийт 13,856,504.3 мянган төгрөгийн төлөгдөөгүй үлдэгдэлд тооцоо нийлж, баталгаажуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5-д "Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 16.5.4.төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх",

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэн гүйцэтгэсэн хайгуулын ажлын зардлын нөхөн төлбөрийн орлоготой холбоотой үүссэн 13,856,504.3 мянган төгрөгийн төлөгдөөгүй үлдэгдэлд тусгай зөвшөөрөл эзэмшигчидтэй нэн даруй тооцоо нийлж, баталгаажуулалт хийж, нөхцөл байдлыг тодорхойлон, барагдуулах арга хэмжээг үе шаттайгаар зохион байгуулах.

### **2. Хөрөнгө бүртгэхтэй холбоотой асуудал**

Илрүүлэлт: Бараа материалын нөөц дансанд бүртгэлтэй 23,175,390.3 мянган төгрөгийн өртөгтэй улсын нөөцийн шатахууныг өнөөгийн бодит өртгөөр (үнэ цэнээр) дахин үнэлж бүртгэлд тусгаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасантай нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Улсын нөөцийн шатахууныг бодит өртгөөр (үнэ цэнээр) дахин үнэлж, нягтлан бодох бүртгэл болон санхүүгийн тайланд үнэн зөв тусгах, цаашид бараа материалын нөөцийн үнэлгээ, бүртгэлийг холбогдох хууль, стандартын дагуу тогтмол хийж, дотоод хяналтыг сайжруулах.

**Илрүүлэлт:** Бараа материалын дансанд дансны ангилал зөрчин үндсэн хөрөнгийн шинж чанартай 388 ширхэг, 89,135.8 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасантай нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Бараа материалын дансанд буруу ангилж бүртгэсэн үндсэн хөрөнгийн шинжтэй 388 ширхэг, 89,135.8 мянган төгрөгийн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандартын дагуу дахин ангилж, зохих дансанд шилжүүлэн бүртгэж, санхүүгийн тайланд үнэн зөв тусгах, мөн цаашид хөрөнгийн ангилал, хүлээн авалт, бүртгэлийн шатанд урьдчилсан болон дараах хяналтыг хэрэгжүүлж, ижил төрлийн зөрчил дахин гаргахгүй байх арга хэмжээ авах.

**Илрүүлэлт:** Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дуусаж, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн боловч ашиглагдаж байгаа 2361 тоотой 8,884,034.3 мянган төгрөгийн дансны үнэ бүхий хөрөнгийг бодит үнэ цэнээр нь үнэлж бүртгээгүй, ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоох саналыг ТӨБЗГ-т хүргүүлж, шийдвэрлүүлээгүй байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 7.1-д "Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ" гэж заасантай нийцээгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Ашиглалтын хугацаа дуусаж, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн боловч ашиглагдаж байгаа 2,361 нэгж, 8,884,034.3 мянган төгрөгийн дансны үнэ бүхий үндсэн хөрөнгийг холбогдох журам, аргачлалын дагуу бодит үнэ цэнээр нь дахин үнэлж, ашиглалтын хугацааг шинэчлэн тогтоох, цаашид ашиглах боломжгүй хөрөнгийг акталж данснаас хасах саналыг Өмч хамгаалах байнгын зөвлөлөөр хэлэлцүүлэн шийдвэрлүүлж, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлэн эцэслэн шийдвэрлүүлж, санхүүгийн тайланд үнэн зөв тусгах.

### **3. Дотоод хяналт, бүртгэл тайлагналтай холбоотой асуудал**

**Илрүүлэлт:** Эрлийн ажил гүйцэтгэх гэрээний хүрээнд бий болсон 26-57 УНА, 61-55 УБИ, 55-14 УНГ, 11-68 УББ, 12-67 УНР, 15-02 УНЦ, 33-42 УБО, 69-96 УБӨ дугаартай нийт 8 тээврийн хэрэгслийг Ашигт малтмал, газрын тосны газрын нэр дээр шилжүүлэн аваагүйгээс эдгээр хөрөнгө шамшигдах эрсдэлтэй байна. Мөн тус байгууллагын нэр дээр бүртгэлгүй 26-57 УНА, 61-55 УБИ, 55-14 УНГ, 11-68 УББ автомашинуудын авто тээврийн хэрэгслийн болон жолоочийн хариуцлагын албан журмын даатгалыг тус байгууллагын батлагдсан төсвөөс төлж, зориулалтын бус зардал гаргасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэж заасантай нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Эрлийн ажил гүйцэтгэх гэрээний хүрээнд шилжүүлэн авсан авто тээврийн хэрэгслийг байгууллагын өмчийн бүртгэлд хууль, стандартын дагуу үнэн зөв тусгаж, зориулалтын дагуу ашиглах, ашиглалт, засвар үйлчилгээ, даатгалтай холбоотой зардлыг батлагдсан төсөв, зориулалтын хүрээнд санхүүжүүлэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Алдааны товч утга	Нийт алдаа		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
						Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	Ашигт малтмал, газрын тосны газрын даргын 2026 оны 1/454 дугаар албан бичгээр Үндэсний аудитын газарт ирүүлсэн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгийн дүн нь нийт өр төлбөр болон цэвэр хөрөнгө, өмчийн дүнтэй 29,407.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна.	1	29,407.0	1	29,407.0	1	29,407.0				
2	Төсвийн гүйцэтгэлийн тайланд улсын төсвийн санхүүжилт болон байгууллагын өөрийн орлогын дүн хоорондоо 2,082,833.9 мянган төгрөгийн зөрүүтэй тайлагнасан	1	2,082,833.9	1	2,082,833.9	1	2,082,833.9				
3	Ашигт малтмал, газрын тосны газрын 2025 оны санхүүгийн тайланг бэлтгэхдээ нийт 5,543.2 мянган төгрөгийн зардал бууруулах бичилт хийсэн байна.	1	5,543.2	1	5,543.2			1	5,543.2	1	5,543.2
	<b>Дүн</b>	<b>3</b>	<b>2,117,784.1</b>	<b>3</b>	<b>2,117,784.1</b>	<b>2</b>	<b>2,112,240.9</b>	<b>1</b>	<b>5,543.2</b>	<b>1</b>	<b>5,543.2</b>

## 6.2. Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөг/

Д/д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Ашигт малтмал, газрын тосны газар нь “Төлөөлөгчийн газрын үйл ажиллагааг дэмжих хөрөнгийг зарцуулах журам”-ын шаардлагыг зөрчин, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын хэрэгцээнд зориулан Номин моторс ХХК-тай АМГТГ/20250102025 дугаартай “Туулах чадвар сайтай автомашин худалдан авах” гэрээ байгуулж, 370,000.0 мянган төгрөгийн өртөгтэй NISSAN Patrol-Y63 маркийн автомашин худалдан авсан байна.		370,000.0				370,000.0		
2	“Төлөөлөгчийн газрын үйл ажиллагааг дэмжих хөрөнгийг зарцуулах журам”-ын шаардлагыг зөрчин, Топика ХХК-тай "Нэвтрэх хаалга, удирдлагын систем худалдан авах" АМГТГ/20250202030 2025/129 дугаар бүхий гэрээ байгуулж, 28,028.6 мянган төгрөгийн өртөгтэй хөрөнгө худалдан авсан байна.	1	28,028.6			1	28,028.6		
3	“Төлөөлөгчийн газрын үйл ажиллагааг дэмжих хөрөнгийг зарцуулах журам”-ын шаардлагыг зөрчин, Чингэлтэй "хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтыг дэмжих төв" ОНӨААТҮГ-тай "Ажил гүйцэтгэх" 2025/132 дугаар бүхий гэрээ байгуулж, Чингэлтэй дүүрэг 4-р хороо Засгийн газрын 12 дугаар байрны гаднах зам талбай тэгшилж цутгах, явган зам засварлах ажилд 19,500.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.		19,500.0				19,500.0		

Ашигт малтмал, газрын тосны газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

4	<p>Газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээний хүрээнд үүссэн авлагын үлдэгдлээс олон жилийн насжилттай, хөөн хэлэлцэх хугацаа дууссан 7 харилцагчтай холбоотой 7,280,058.9 мянган төгрөгийн авлага, мөн хөөн хэлэлцэх хугацаандаа байгаа боловч тооцоо нийлж баталгаажуулаагүй 2 харилцагчтай холбоотой 829,768.5 мянган төгрөгийн авлага тус тус байгууллагаас авах авлагын дансанд бүртгэлтэй байна. Дээрх нийт 8,109,827.4 мянган төгрөгийн авлагыг барагдуулах, шүүхийн болон шүүхийн өмнөх журмаар шаардах, тооцоо нийлж баталгаажуулах, холбогдох хариуцлагын арга хэмжээ авах чиглэлээр байгууллагын үе үеийн удирдлага, хариуцсан албан тушаалтнууд бодитой, үр дүнтэй арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй байна.</p>	1	8,109,827.4			1	8,109,827.4		
5	<p>Засгийн газрын 2025 оны 34 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх хүрээнд Ашигт малтмал, газрын тосны газрын даргын А/86, А/128 дугаар тушаалаар гэрээгээр шатахуун хадгалагч 7 компанид хадгалагдаж байсан зуны дизель түлшний улсын нөөцөөс 5,191.6 тонн түлшийг зах зээлийн үнээр борлуулж, олсон орлогоор ТС-1 онгоцны түлшний улсын нөөц бүрдүүлэх чиг үүргийг “Эрчис-Ойл” ТӨХХК-нд хариуцуулсан байна. Уг чиглэлийн дагуу “Эрчис-Ойл” ХХК тайлант онд 3,506.8 тонн дизель түлшийг 6 компаниас хүлээн авч 9,821,992.9 мянган төгрөгөөр борлуулсан боловч энэ гүйлгээтэй холбоотой бараа материалын тооцоо, авлага, өглөгийг Ашигт малтмал, газрын тосны газар санхүүгийн тайландаа бүртгээгүй байна.</p>	1	9,821,992.9			1	9,821,992.9		
6	<p>Сонгон шалгаруулах тендерт шалгараагүй 68 харилцагчид өгөх 1,133,122.6 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэсэн, 55 харилцагчтай тооцоо нийлж баталгаажуулаагүй байна. Мөн Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн А/102 дугаар тушаалаар баталсан “Сонгон шалгаруулалтын журам”-д тендерт шалгараагүй компаниудын босго үнийн төлбөрийг буцаан олгох зохицуулалт тусгагдаагүй байна.</p>	1	1,133,122.6			1	1,133,122.6		

Ашигт малтмал, газрын тосны газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

7	Газрын тос болон уламжлалт бус газрын тосны эрлийн гэрээг 2022–2025 онд байгуулсан 6 аж ахуйн нэгж нь гэрээний 3 дугаар зүйлийн 3.4.10-д заасан, “Компани нь энэхүү гэрээний 3.1.3-т заасан Ашигт малтмал, газрын тосны газраас томилогдсон мэргэжилтний ажил үүргээ гүйцэтгэхэд шаардагдах 1 ширхэг автомашин (жийп ангиллын, туулах чадвар сайтай, шинэ, дизель хөдөлгүүртэй)-ыг худалдан авч Ашигт малтмал, газрын тосны газарт буцалтгүйгээр хүлээлгэн өгөх” үүргээ биелүүлээгүй байна.	1	0.0			1	0.0		
8	Нэг ижил объектод хамаарах (нэг хуулийн төсөл), нэг ижил эцсийн үр дүнтэй (хуулийн төсөлд санал, дүгнэлт боловсруулах), нэг гүйцэтгэгчээр, нэг хугацаанд гүйцэтгэх нийт 36,000.0 мянган төгрөгийн өртөг бүхий ажлыг шууд гэрээ байгуулах зорилгоор төсөвт өртгийг хувааж, Ажиглалт ХХК-тай 2025 оны 09 дүгээр сарын 22-ны өдөр 2025/123, 2025/124 дугаартай “Ажил гүйцэтгэх гэрээ”-г тус тус байгуулан, гэрээ тус бүрийн үнийг 18,000.0 мянган төгрөгөөр тогтоож, ажлыг гүйцэтгүүлсэн байна.	1	36,000.0			1	36,000.0		
9	Ашигт малтмал, газрын тосны газрын даргын 2025 оны А/249 дүгээр тушаалын дагуу “Бизнес процесс менежмент” ХХК-тай 2025/137, “Актуариал солюшнс” ХХК-тай 2025/136 дугаар бүхий “Зөвлөх үйлчилгээ үзүүлэх” гэрээнүүдийг тус тус байгуулж, гүйцэтгэх ажил, санхүүжилтийг хоёр төсвийн жил дамнуулан хэрэгжүүлэхээр тохиролцон, урьдчилгаа төлбөрт нийт 19,800.0 мянган төгрөгийг шилжүүлсэн байна.	1	19,800.0			1	19,800.0		
10	Ашигт малтмал, газрын тосны газар нь Ухаалаг шийдэл ХХК-тай 2019 онд 1931 дугаартай “Эрдэм шинжилгээ, судалгааны ажил гүйцэтгэх зөвлөх үйлчилгээний гэрээ” байгуулж, газрын тосны бүтээгдэхүүний импорт, үлдэгдэл, үнэ болон борлуулалтын мэдээ, мэдээллийг нэгтгэн боловсруулах mpetro.smartsolution.mn системийг нийт 255,000.0 мянган төгрөгийн өртгөөр хүлээн авч, 2020 оноос ашиглаж эхэлсэн боловч уг системийг биет бус хөрөнгийн бүртгэлд тусгаагүй байна.	1	255,000.0			1	255,000.0		

Ашигт малтмал, газрын тосны газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

11	Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэн гүйцэтгэсэн хайгуулын ажлын зардлын нөхөн төлбөрийн орлоготой холбоотойгоор 1998–2016 онд тусгай зөвшөөрөл эзэмшсэн 12 эзэмшигчид хамаарах 2,398,398.39 ам.долларын үлдэгдэл (ханш 1 ам.доллар = 3,556.66 төгрөг), мөн 2017–2025 онд тусгай зөвшөөрөл эзэмшсэн 20 эзэмшигчид хамаарах 5,326,216.7 мянган төгрөгийн үлдэгдэл, нийт 13,856,504.3 мянган төгрөгийн төлөгдөөгүй үлдэгдэлд тооцоо нийлж, баталгаажуулаагүй байна.	1	13,856,504.3					1	13,856,504.3
12	Бараа материалын нөөц дансанд бүртгэлтэй 23,175,390.3 мянган төгрөгийн өртөгтэй улсын нөөцийн шатахууныг өнөөгийн бодит өртгөөр (үнэ цэнээр) дахин үнэлж бүртгэлд тусгаагүй байна.	1	23,175,390.3					1	23,175,390.3
13	Бараа материалын дансанд дансны ангилал зөрчин үндсэн хөрөнгийн шинж чанартай 388 ширхэг, 89,135.8 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэсэн байна.	1	89,135.8					1	89,135.8
14	Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дуусаж, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн боловч ашиглагдаж байгаа 2361 тоотой 8,884,034.3 мянган төгрөгийн дансны үнэ бүхий хөрөнгийг бодит үнэ цэнээр нь үнэлж бүртгээгүй, шинэчлэн тогтоох саналыг ТӨБЗГ-т хүргүүлж, шийдвэрлүүлээгүй байна.	1	8,884,034.3					1	8,884,034.3
15	Эрлийн ажил гүйцэтгэх гэрээний хүрээнд бий болсон 26-57 УНА, 61-55 УБИ, 55-14 УНГ, 11-68 УББ, 12-67 УНР, 15-02 УНЦ, 33-42 УБО, 69-96 УБӨ дугаартай нийт 8 тээврийн хэрэгслийг Ашигт малтмал, газрын тосны газрын нэр дээр шилжүүлэн аваагүйгээс эдгээр хөрөнгө шамшигдах эрсдэлтэй байна. Мөн тус байгууллагын нэр дээр бүртгэлгүй 26-57 УНА, 61-55 УБИ, 55-14 УНГ, 11-68 УББ автомашинуудын авто тээврийн хэрэгслийн болон жолоочийн хариуцлагын албан журмын даатгалыг тус байгууллагын батлагдсан төсвөөс төлж, зориулалтын бус зардал гаргасан байна.	1	0.0					1	0.0
<b>Дүн</b>		<b>13</b>	<b>65,798,336.2</b>			<b>8</b>	<b>19,793,271.5</b>	<b>5</b>	<b>46,005,064.7</b>

**6.3. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөг/

Д/д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	“Алсын хараа–2050” урт хугацааны бодлогын баримт бичгийн хүрээнд уул уурхайн салбарын хариуцлагатай хөгжил, нөхөн сэргээлт, ордын ашиглалтын гэрээний хэрэгжилт зэрэг 4 арга хэмжээний хэрэгжилт дунджаар 77.5 хувьтай үнэлэгдэж, “үр дүн хүлээгдэж буй” ангилалд хамаарсан байна. Үүнээс: Байгаль орчны нөхөн сэргээлтийн ажлын биелэлт хангалтгүй, олон улсын стандартыг мөрдөх шаардлагын хэрэгжилт бүрэн хангагдаагүй бөгөөд ордын ашиглалтын гэрээний шинэчилсэн төсөл эцэслэгдээгүй байна								
2	“Засгийн газрын 2024–2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан нийт найман арга хэмжээний хэрэгжилт дунджаар 81.8 хувьтай үнэлэгдэж, үүнээс Цагаансуврага зэс-молибденийн ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах төсөл зорилтот түвшинд хүрээгүй 65 хувьтай үнэлэгдсэн байна	1	-					1	-
3	Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд туссан 10 арга хэмжээний хэрэгжилт дунджаар 77.5 хувийн биелэлттэй үнэлэгдсэн байна. Үүний дотор Рашаант дахь улсын нөөцийн агуулах төслийн хэрэгжилт бүрэн хангагдаагүй 50 хувьтай, Цагаансуврага зэс-молибденийн ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах төсөл 65 хувьтай үнэлэгдсэн байна								
4	‘Шинэ сэргэлтийн бодлого’-д туссан гурван арга хэмжээний хэрэгжилт дунджаар 81.6 хувьтай үнэлэгдсэн байна. Гэвч нөхөн сэргээлтийн ажлын зарим хэсэг ‘үр дүн хүлээгдэж буй’ ангилалд багтсан бөгөөд техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн биелэлт зорилтот түвшинд хүрээгүй байна. Мөн газрын тосны бүтээгдэхүүний импортын хангамжийн тогтвортой байдалд тодорхой хэмжээний эрсдэл хэвээр байна								

Ашигт малтмал, газрын тосны газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

5	<p>Ашигт малтмал, газрын тосны газрын үндсэн чиг үүрэгт хамаарах Засгийн газрын 10 тогтоол, 3 тэмдэглэлийн нийт 17 заалтын хэрэгжилт дунджаар 88.8 хувьтай үнэлэгдсэн байна. Гэвч Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн хэрэгжилт 63.3 хувьд хүрсэн бөгөөд зарим заалтын хэрэгжилт хангалтгүй байна. Тухайлбал, бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулах эрх олгосон хэд хэдэн тохиолдолд хэрэгжилтийн хугацаа хоцорч, зарим компани гэрээ байгуулахаас татгалзсан нь тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн үр нөлөөг бууруулсан байна. Мөн Засгийн газрын тогтоолоор олгосон эрхийг хуульд заасан хугацаанд хэрэгжүүлээгүй байна. /жишээ нь 'Петроматад' ХХК-ийн Дарьганга XXIV талбайн гэрээний хэрэгжилт/;</p>							
6	<p>Ашигт малтмал, газрын тосны газар нь газрын тосны бүтээгдэхүүний нийлүүлэлт, хангамжийн тогтвортой байдлыг хангах чиг үүргийн зарим хэсгийг бодитой хэрэгжүүлээгүйгээс Аи-92 болон К5 (Евро-5) автобензиний импорт, нөөц бүрдүүлэлт, түгээлтийн төлөвлөлт, зохион байгуулалт, уялдаа хангалтгүй байсан бөгөөд үүний үр дагаварт зах зээлд шатахууны хомсдол үүсэж, иргэдийн шатахуун авах боломж хязгаарлагдан, олон нийтийн дунд бухимдал бий болгосон байна</p>							
7	<p>Байгууллагын мэдээллийн аюулгүй байдлын бодлого, журам болон холбогдох хууль, эрх зүйн актуудыг бүх албан хаагчдад танилцуулах, хэрэгжилтийг хянах, дотоод хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоо бүрдүүлэх үйл ажиллагаа хангалтгүй байна. Мэдээллийн аюулгүй байдлын асуудал хариуцсан нэгж, албан тушаалтан томилоогүй бөгөөд хэрэгжилтийн хяналт, дотоод тайлагнал тогтмол хийгдээгүй байна.</p>	1	-				1	-
8	<p>Сервер болон мэдээллийн бааз доголдсон үед үйл ажиллагааг тасралтгүй үргэлжлүүлэх сэргээн босголтын нөөц систем, төлөвлөгөө боловсруулаагүй, баталгаажуулсан баримт бичиггүй байна. Мөн кибер халдлагын үед авах хариу арга хэмжээний төлөвлөгөө (Incident Response Plan) батлагдаагүй бөгөөд туршилт, сорилт хийгдээгүй байна.</p>							

Ашигт малтмал, газрын тосны газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

9	<p>Санхүүгийн болон бусад мэдээллийн системд нэвтрэх эрхийн хяналт сул, хэрэглэгчийн эрхийн түвшинг тодорхойлсон журам бүрэн мөрдөгдөөгүй байна. Хэрэглэгчийн үйлдлийн лог бүртгэл хангалтгүй, систем дотор хийгдсэн бүх үйлдэл, өөрчлөлт, гүйлгээг цаг хугацааны дарааллаар бүртгэж хадгалах зохицуулалт бүрдээгүй байна.</p>								
10	<p>Ашигт малтмал, газрын тосны газрын дарга нь байгууллагын үйл ажиллагаанд шаардагдах зарим албан тушаалын чиг үүргийг гүйцэтгүүлэхдээ Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу хөдөлмөрийн гэрээ байгуулаагүй, Иргэний хуулийн дагуу ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан байна. Тухайлбал, үйлчлэгч, цэвэрлэгч, архивч, бичиг хэргийн ажилтан, орон нутгийн төлөөлөгч, жолооч зэрэг байнгын шинжтэй, байгууллагын үндсэн үйл ажиллагаанд хамаарах ажлын үүргийг ажил гүйцэтгэх гэрээний хэлбэрээр гүйцэтгүүлж, эдгээр ажилтнуудад сар бүр төрийн үйлчилгээ (ТҮ) болон төсвийн захирагчийн (ТЗ) зэрэглэлээр цалин, урамшуулал тооцож олгож байгаа нь хууль тогтоомжийн шаардлагыг зөрчсөн байна.</p>	1	-				1		-
11	<p>Ашигт малтмал, газрын тосны газрын дарга нь Төрийн албаны тухай хуульд заасны дагуу төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгүүлэх тохиолдолд 14 хоногийн дотор шийдвэр гаргаж, холбогдох нэмэгдэл хөлсийг тооцох ёстой боловч энэхүү хугацааг мөрдөөгүй байна. Тухайлбал:</p> <ul style="list-style-type: none"> <li>• 2024 оны 06 дугаар сарын 24-ний өдрөөс эхлэн албан үүргийг зэрэгцээ хавсран гүйцэтгэж буй албан хаагчид нэмэгдэл олгох шийдвэрийг 2025 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн Б/05 дугаар тушаалаар,</li> <li>• 2024 оны 08 дугаар сарын 05-ны өдрөөс эхлэн хавсран гүйцэтгэж буй албан хаагчид нэмэгдэл олгох шийдвэрийг 2025 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн Б/34 дугаар тушаалаар,</li> <li>• 2024 оны 11 дүгээр сарын 02-ны өдрөөс эхлэн хавсран гүйцэтгэж буй албан хаагчид нэмэгдэл олгох шийдвэрийг 2025 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн Б/103 дугаар тушаалаар,</li> <li>• 2025 оны 02 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн хавсран гүйцэтгэж буй албан хаагчид нэмэгдэл олгох шийдвэрийг 2025 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн Б/112 дугаар тушаалаар тус тус гаргасан байна.</li> </ul>	1	-				1		-

Ашигт малтмал, газрын тосны газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

12	Ашигт малтмал, газрын тосны газрын төрийн захиргааны албан тушаалын үндсэн орон тоонд хамаарах нийт 26 албан тушаалтан нь төрийн албан хаагчийн шалгалт өгч, тангараг өргөөгүй түр томилгоотой, 2 албан хаагчийг тусгай шалгалт явуулалгүйгээр албан тушаалд томилсон байна. /удирдах түвшний 6, гүйцэтгэх түвшний 22/ Тухайлбал: Тус байгууллагын сүүлийн 4 агентлагийн дарга нь албан үүргийг түр орлон гүйцэтгэгч томилгоотой байсан байна.	1	-					1	-
13	Албан хаагчидтай байгуулсан хөдөлмөрийн гэрээ болон Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрт заасны дагуу орон нутагт томилолтоор ажил үүргээ гүйцэтгэдэг албан хаагчдад нормын хувцас олгодог боловч байгууллагын Хөдөлмөрийн дотоод журам, НБББББ болон бусад холбогдох журмуудад нормын хувцасны эдэлгээний хугацааг тодорхой заагаагүйгээс ашиглалтын хугацаа дууссан, олон жил болсон хувцас хэрэгслийг акталж данснаас хасах ажиллагаа хийгдээгүй, бараа материалын бүртгэлд үлдэгдэлтэй хэвээр байна.	1	-					1	-
<b>Дүн</b>		<b>6</b>	<b>0.0</b>					<b>6</b>	<b>0.0</b>



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 23 өдөр

Дугаар 09/А0160056

Улаанбаатар хот

САГ-2026/19/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Ашигт малтмал, газрын тосны газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Газрын тос болон уламжлалт бус газрын тосны эрлийн гэрээг 2022–2025 онд байгуулсан 6 аж ахуйн нэгж нь гэрээний 3 дугаар зүйлийн 3.4.10-д заасан, “Компани нь энэхүү гэрээний 3.1.3-т заасан Ашигт малтмал, газрын тосны газраас томилогдсон мэргэжилтний ажил үүргээ гүйцэтгэхэд шаардагдах 1 ширхэг автомашин (жийп ангиллын, туулах чадвар сайтай, шинэ, дизель хөдөлгүүртэй)-ыг худалдан авч Ашигт малтмал, газрын тосны газарт буцалтгүйгээр хүлээлгэн өгөх” үүргээ биелүүлээгүй байна.


Энэ нь Иргэний хуулийн 206 дугаар зүйлийн 206.1-д “Үүргийг тогтоосон газар, хугацаанд нь, зохих ёсоор, шударгаар гүйцэтгэнэ”, 208 дугаар зүйлийн 208.1-д “Үүргийг хууль буюу гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэнэ”, 211 дүгээр зүйлийн 211.1-д “Үүргийн гүйцэтгэлийг үүрэг гүйцэтгүүлэгчид, эсхүл хууль, гэрээ буюу шүүх, арбитрын шийдвэрт заасан эрх бүхий этгээдэд хүлээлгэж өгнө” гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.8-д “байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

- Газрын тос болон уламжлалт бус газрын тосны эрлийн гэрээг 2022–2025 онд байгуулсан 6 аж ахуйн нэгж нь Ашигт малтмал, газрын тосны газраас томилогдсон мэргэжилтний ажил үүргээ гүйцэтгэхэд шаардагдах тус бүр 1 ширхэг автомашин (жийп ангиллын, туулах чадвар сайтай, шинэ, дизель хөдөлгүүртэй)-ыг худалдан авч Ашигт малтмал, газрын тосны газарт хүлээлгэн өгөх үүргээ биелүүлээгүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
- Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Ашигт малтмал, газрын тосны газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /П.Баянбаатар/, ахлах нягтлан бодогч /С.Отгонжаргал/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ  
Д.ЭНХДАЛАЙ  
А.ДАВААДОРЖ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,  
Утас 51-261230

Z:\Alban Shoardlaga\2026\0123\_SAG-3.Docx

1526180033



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 23 өдөр

Дугаар 10/А0160056

Улаанбаатар хот

САГ-2026/19/НА-СТА-ТШЗ

Зөрчлийг таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Ашигт малтмал, газрын тосны газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нэг ижил объектод хамаарах (нэг хуулийн төсөл), нэг ижил эцсийн үр дүнтэй (хуулийн төсөлд санал, дүгнэлт боловсруулах), нэг гүйцэтгэгчээр, нэг хугацаанд гүйцэтгэх нийт 36,000,000.00 /Гучин зургаан сая/ төгрөгийн өртөг бүхий ажлыг шууд гэрээ байгуулах зорилгоор төсөвт өртгийг хувааж, "Ажиглалт" ХХК-тай 2025 оны 09 дүгээр сарын 22-ны өдөр 2025/123, 2025/124 дугаартай "Ажил гүйцэтгэх гэрээ"-г тус тус байгуулан, гэрээ тус бүрийн үнийг 18,000,000.00 /Арван найман сая/ төгрөгөөр тогтоож, ажлыг гүйцэтгүүлсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2-т "Энэ хуулийн 31.2-т зааснаас бусад тохиолдолд нийт төсөвт өртөг нь шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээг захиалагч шууд худалдан авч болно", 10.3-т "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.9-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шууд гэрээ байгуулах зорилгоор төсөвт өртгийг хувааж гэрээ байгуулдаг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Ашигт малтмал, газрын тосны газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /П.Баянбаатар/, ахлах нягтлан бодогч /С.Отгонжаргал/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ  
Д.ЭНХДАЛАЙ  
А.ДАВААДОРЖ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-261230

Z: Alban Shaardlaga2026-0123 SAG-3.Docx

1526180035



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 23 өдөр

Дугаар 11/АД160056

Улаанбаатар хот

САГ-2026/19/НА-СТА-ТШЗ

Зөрчлийг таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Ашигт малтмал, газрын тосны газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Ашигт малтмал, газрын тосны газрын даргын 2025 оны А/249 дүгээр тушаалын дагуу "Бизнес процесс менежмент" ХХК-тай 2025/137, "Актуариал солишнс" ХХК-тай 2025/136 дугаар бүхий "Зөвлөх үйлчилгээ үзүүлэх" гэрээнүүдийг тус тус байгуулж, гүйцэтгэх ажил, санхүүжилтийг хоёр төсвийн жил дамнуулан хэрэгжүүлэхээр тохиролцон, урьдчилгаа төлбөрт нийт 19,800,000.00 /Арван есөн сая найман зуун мянган/ төгрөгийг шилжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.5-д "Төсвийн захирагч нь энэ хуулийн 43.1.3, 43.1.5-д зааснаас бусад төсвийг хоёр төсвийн жил дамжуулан зарцуулахгүй" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.8-д "байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хоёр төсвийн жил дамнуулан хэрэгжүүлэхээр гэрээ байгуулж, урьдчилгаа санхүүжилт олгодог зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Ашигт малтмал, газрын тосны газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /П.Баянбаатар/, ахлах нягтлан бодогч /С.Отгонжаргал/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ  
Д.ЭНХДАЛАЙ  
А.ДАВААДОРЖ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-261230

Z:\Alban Shaardlaga\2026\0123\SAG-3.Docx

1526180037



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 23 өдөр

Дугаар 12/АД160056

Улаанбаатар хот

САГ-2026/19/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Ашигт малтмал, газрын тосны газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Ашигт малтмал, газрын тосны газар нь Ухаалаг шийдэл ХХК-тай 2019 онд 1931 дугаартай "Эрдэм шинжилгээ, судалгааны ажил гүйцэтгэх зөвлөх үйлчилгээний гэрээ" байгуулж, газрын тосны бүтээгдэхүүний импорт, үлдэгдэл, үнэ болон борлуулалтын мэдээ, мэдээллийг нэгтгэн боловсруулах mpetro.smartsolution.mn системийг нийт 255,000,000.00 /Хоёр зуун тавин таван сая/ төгрөгийн өртгөөр гүйцэтгүүлэн хүлээн авч, 2020 оноос ашиглаж эхэлсэн боловч уг системийг биет бус хөрөнгийн бүртгэлд тусгаагүй байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-т "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална:", 5.1.2-т "тасралтгүй байх,"; 5.1.4-т "үнэн зөв байх", 6 дугаар зүйлийн 6.1-т "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө", 13 дугаар зүйлийн 13.4-т "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна", 14 дүгээр зүйлийн 14.2.2-т "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага;" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1-д "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Mpetro.smartsolution.mn системийг биет бус хөрөнгийн бүртгэлд бүртгээгүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Ашигт малтмал, газрын тосны газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /П.Баянбаатар/, ахлах нягтлан бодогч /С.Отгонжаргал/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ  
Д.ЭНХДАЛАЙ  
А.ДАВААДОРЖ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 5-р хороо, Бага тогруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-26-230

Z:\Alban Shaardlaga\2026\0123\SAГ-3.Docx

1526180039



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 23 өдөр

Дугаар 13/АД160056

Улаанбаатар хот

САГ - 2026 / 19 / НА - СТА - ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Ашигт малтмал, газрын тосны газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Сонгон шалгаруулах тендэрт шалгараагүй 68 харилцагчид өгөх 1,133,122,664.00 /Нэг тэрбум нэг зуун гучин гурван сая нэг зуун хорин хоёр мянга зургаан зуун жаран дөрвөн/ төгрөгийн өр төлбөр үүсгэсэн, 55 харилцагчтай тооцоо нийлж баталгаажуулаагүй байна. Мөн Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн А/102 дугаар тушаалаар баталсан "Сонгон шалгаруулалтын журам"-д тендэрт шалгараагүй компаниудын босго үнийн төлбөрийг буцаан олгох зохицуулалт тусгагдаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.7-д "авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Сонгон шалгаруулах тендэрт шалгараагүй 55 харилцагчтай тооцоо нийлж баталгаажуулаагүй, "Сонгон шалгаруулалтын журам"-д тендэрт шалгараагүй компаниудын босго үнийн төлбөрийг буцаан олгох зохицуулалтыг тусгаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Ашигт малтмал, газрын тосны газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /П.Баянбаатар/, ахлах нягтлан бодогч /С.Отгонжаргал/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ  
Д.ЭНХДАЛАЙ  
А.ДАВААДОРЖ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,  
Утас 51-261230

Z:\Alban Shaardluga\2026\0123\SAГ-3.Docx

1526180031

Өглөгийн дэлгэрэнгүй бүртгэл

Хавсралт №1

Д/д	Нэр	Эцсийн үлдэгдэл	Тооцоо
		2025.12.31	нийлсэн эсэх
<b>413600-0002 - Бусад өглөг /Сонгон шалгаруулалт/</b>			
1	Литиум сенчури-ХХК, 5745721	2,826,810.00	Тийм
2	МОНГОЛИАН НАН ФАН МАЙНИНГ ИНВЕСТМЕНТ ХХК, 6805752	1,932,910.00	Тийм
3	Платинум Интернешнл Ложистик ХХК, 5372356	901,305.00	
4	Луна ворлд ХХК, 5230691	3,026,520.00	
5	Төгс Прогресс ХХК	1,555,335.00	
6	Үнэт Аз ХХК, 6875025	1,086,820.00	
7	Монгол 333 корпораци ХХК, 5946743	563,710.00	
8	Хөлцөөтийн арвин металлс ХХК, 8404445	295,335.00	
9	Орд талст ресурс ХХК, 6993311	1,132,600.00	
10	Писуччи ХХК, 6835481	2,550,240.00	
11	Түмэн айл нөөц ХХК, 6995071	93,134,565.00	
12	Эрдэнэс болор майнинг ХХК	4,435,560.00	
13	Геопионер эксплорейшн ХХК, 8472351	518,294.00	
14	Баянмогул ХХК	250,000.00	
15	Вивид Минералс ХХК	1,663,335.00	
16	Нинжин тулгат майнинг ХХК	4,435,560.00	
17	Хас баян жонш ХХК	4,435,560.00	
18	Дархан эрхэт майнинг ХХК	3,206,610.00	
19	Мөнх ундрах ресурс ХХК, 5679141	891,870.00	
20	Зэлтэр бэйс ХХК	55,415,710.00	
21	Эм эн ар си ХХК, 5543444	2,336,810.00	Тийм
22	Монгол газар корпорэйшн проперти ХХК, 6582786	195,300.00	
23	Фаст Стөүн ХХК	100.00	
24	Монголиа хуа рун шин майнинг ХХК	152,779,130.00	Тийм
25	Уяач металл ресурс ХХК	437,220.00	
26	Нэт критикал минералс ХХК	65,969,680.00	
27	Денали эрдэнэ майнинг ХХК	10,490,410.00	
28	Харли Инноватор Жэмстони ХХК	891,870.00	Тийм
29	Хишиг арвижих ХХК, 7094153	450,000.00	
30	Гоулд Минералс ХХК	13,590,290.00	
31	Хаан алт хүдэр ХХК	13,590,290.00	
32	Пи би ай ресурс девелопмент ХХК	13,026,580.00	
33	Түмэн айл гоулд ХХК	69,948,550.00	
34	Эвсэг хамтын хүч ХХК	13,026,580.00	
35	Тангшан жинша монгол ХХК	1,506,820.00	
36	Спэйшл монди трэнд ХХК	195,300.00	
37	Этернал терра майнинг ХХК	759,010.00	
38	Гоулд титанс ХХК	8,901,270.00	
39	Хармаг манхан говь ХХК, 6996949	3,291,120.00	Тийм
40	Талын цэнхэг трейд ХХК, 3638979	55,415,710.00	
41	Титан эрдэнэ майнинг ХХК, 7134897	891,870.00	Тийм
42	Даймонд Ворлд Номадик	891,870.00	Тийм
43	Нэг удаагийн харилцагч	436,325,930.00	
44	Сангийн яам, 9131787	50,000.00	
45	Монгол чех металл ХХК, 5051134	1,402,030.00	
46	Си Өү Эй Эл ХХК, 5261198	13,603,590.00	Тийм
47	Цагаан уулын магнит ХХК, 5103193	288,680.00	
48	АШМАГ ХХК, 5155614	759,010.00	
49	Хунт өгөөж ХХК, 2166631	20,883,310.00	Тийм
50	Баян жонш ХХК, 2696304	4,435,560.00	

51	Жингийн гол ХХК, 5087457	1,663,335.00	
52	Баян сүмбэр богд ХХК, 5065844	759,010.00	Тийм
53	Минторес ххк, 5111919	891,870.00	
54	Суммус ХХК, 5736609	798,140.00	
55	ЭБЭГ ХХК, 5353203	4,987,080.00	
56	Өгөөжбаян хангай ххк, 5515882	2,383,710.00	
57	гео футур консалтинг ххк, 6010792	4,435,560.00	
58	Хан рояал ххк, 5994152	8,374,230.00	
59	Баянгол тариалан ХХК, 6188419	288,680.00	
60	ТЭЗҮ ХХК, 5665388	2,714,810.00	Тийм
61	Алтантоонот Өргөө ХХК, 5323843	2,336,810.00	Тийм
62	олон одох ххк, 6209475	100.00	
63	Азиан майнинг ресорсе ххк	867,285.00	
64	Оймон, 5017629	891,870.00	Тийм
65	Топ ган дриллинг ХХК, 6268048	891,870.00	
66	Мөнгөн нуруу ХХК, 6470556	295,400.00	
67	Инженер план ХХК, 5942144	753,625.00	
68	Стид майнинг ХХК, 6381928	9,196,740.00	
	-	<b>1,133,122,664.00</b>	



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 23 өдөр

Дугаар 14/АД160056

Улаанбаатар хот

САГ - 2026/19/НА - СТА - ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Ашигт малтмал, газрын тосны газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Засгийн газрын 2025 оны 34 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх хүрээнд Ашигт малтмал, газрын тосны газрын даргын А/86, А/128 дугаар тушаалаар гэрээгээр шатахуун хадгалагч 7 компанид хадгалагдаж байсан зуны дизель түлшний улсын нөөцөөс 5,191.6 тонн түлшийг зах зээлийн үнээр борлуулж, олсон орлогоор ТС-1 онгоцны түлшний улсын нөөц бүрдүүлэх чиг үүргийг “Эрчис-Ойл” ТӨХХК-нд хариуцуулсан байна.

Уг чиглэлийн дагуу “Эрчис-Ойл” ТӨХХК тайлант онд 3,506.8 тонн дизель түлшийг 6 компаниас хүлээн авч 9,821,992,976.00 /Есөн тэрбум найман зуун хорин нэгэн сая есөн зуун ерэн хоёр мянга есөн зуун далан зургаан/ төгрөгөөр борлуулсан боловч энэ гүйлгээтэй холбоотой бараа материалын тооцоо, авлага, өглөгийг Ашигт малтмал, газрын тосны газар санхүүгийн тайландаа бүртгээгүй, үлдэгдлийг баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ:”, 14.4.1-д “аж ахуйн бүх ажил, гүйлгээ;”, 14.4.5-д “бүх орлого;”, 14.4.6-д “бүх зардал”, 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасныг тус тус хэрэгжүүлээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.1-д “нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Засгийн газрын 2025 оны 34 дүгээр тогтоолын хэрэгжилтийн хүрээнд шатахуун хадгалж, борлуулсан болон “Эрчис-Ойл” ХХК-д хариуцуулсан дизель, ТС-1 түлштэй холбоотой бараа материал, өглөг, авлагын тооцоог бүрэн хийж, баталгаажуулаагүй, санхүү бүртгэлд тусгаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Ашигт малтмал, газрын тосны газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /П.Баянбаатар/, ахлах нягтлан бодогч /С.Отгонжаргал/ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**  
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ  
Д.ЭНХДАЛАЙ  
А.ДАВААДОРЖ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 23 өдөр

Дугаар 15/A0160056

Улаанбаатар хот

САГ-2026/19/НА-СТА-ТШЗ

Зөрчлийг таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Ашигт малтмал, газрын тосны газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Ашигт малтмал, газрын тосны газар нь "Төлөөлөгчийн газрын үйл ажиллагааг дэмжих хөрөнгийг зарцуулах журам"-д нийцээгүй зорилго, зориулалтаар нийт 417,528,600.00 /Дөрвөн зуун арван долоон сая таван зуун хорин найман мянга зургаан зуун/ төгрөгийн хөрөнгийг зарцуулсан байна. Үүнд:

- Топика ХХК-тай АМГТГ/20250202030, 2025/129 дугаар бүхий "Нэвтрэх хаалга, удирдлагын систем худалдан авах" гэрээ байгуулж, 28,028,600.00 төгрөгийн өртөг бүхий хөрөнгө худалдан авсан;
- Чингэлтэй "Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтыг дэмжих төв" ОНӨААТҮГ-тай 2025/132 дугаар бүхий "Ажил гүйцэтгэх" гэрээ байгуулж, Чингэлтэй дүүргийн 4 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах Засгийн газрын 12 дугаар байрны гаднах зам, талбайг тэгшилж цутгах, явган зам засварлах ажилд 19,500,000.00 төгрөгийг зарцуулсан;
- Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын хэрэгцээнд зориулан Номин моторс ХХК-тай АМГТГ/20250102025 дугаартай "Туулах чадвар сайтай автомашин худалдан авах" гэрээ байгуулж, 370,000,000.00 төгрөгийн өртөгтэй NISSAN Patrol-Y63 маркийн автомашин худалдан авсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2.2-т "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах" гэж заасантай, Ашигт малтмал, газрын тосны газрын даргын 2025 оны А/15 дугаар тушаалаар баталсан "Төлөөлөгчийн газрын үйл ажиллагааг дэмжих хөрөнгийг зарцуулах журам"-ын 3.1.1-т "Газрын тосны хайгуул, ашиглалт, борлуулалт, тээвэрлэлтийн үйл ажиллагаанд хяналт тавихад шаардлагатай автомашин, зөөврийн орон сууц, техник, тоног төхөөрөмж зэрэг үндсэн хөрөнгийг худалдан авах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.6-д "төсвийг зориулалт

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-266230

Z:\Alban Shaardlaga\2026-0123 SAG-3.Docx

1526180025

бусаар зарцуулсан”, 4.2.1.8-д “байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. “Төлөөлөгчийн газрын үйл ажиллагааг дэмжих хөрөнгийг зарцуулах журам”-д нийцээгүй зорилго, зориулалтаар зардал гаргадаг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Ашигт малтмал, газрын тосны газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /П.Баянбаатар/, ахлах нягтлан бодогч /С.Отгонжаргал/ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**  
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ  
Д.ЭНХДАЛАЙ  
А.ДАВААДОРЖ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 23 өдөр

Дугаар 16/АД160056

Улаанбаатар хот

САГ-2026/19/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Ашигт малтмал, газрын тосны газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээний хүрээнд үүссэн авлагын үлдэгдлээс олон жилийн насжилттай, 9 харилцагчтай холбоотой нийт 8,109,827,446.86 /Найман тэрбум нэг зуун есөн сая найман зуун хорин долоон мянга дөрвөн зуун дөчин зургаан төгрөг, наян зургаан мөнгө/ төгрөгийн авлагыг барагдуулах, шүүхийн болон шүүхийн өмнөх журмаар шаардах, тооцоо нийлж баталгаажуулах, холбогдох хариуцлагын арга хэмжээ авах чиглэлээр байгууллагын үе үеийн удирдлага, хариуцсан албан тушаалтнууд бодитой, үр дүнтэй арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 16.1-т "Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.7-д "авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

- Газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээний хүрээнд үүссэн олон жилийн насжилттай авлагыг барагдуулах, шүүхийн болон шүүхийн өмнөх журмаар шаардах, тооцоо нийлж баталгаажуулах, холбогдох хариуцлагын арга хэмжээ авах чиглэлээр бодитой, үр дүнтэй арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй зөрчлийг арилган биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
- Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Ашигт малтмал, газрын тосны газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /П.Баянбаатар/, ахлах нягтлан бодогч /С.Отгонжаргал/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ  
Д.ЭНХДАЛАЙ  
А.ДАВААДОРЖ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,  
Утас 51-204230



Z:\Alban Shaardlaga\2026\0123.SAG-3.Docx

1526180027

Авлагын дэлгэрэнгүй бүртгэл

Хавсралт №1

Д/д	Нэр	Дүн	Тайлбар
1	Гоби энерги партнест ХХК	2,419,930,707.70	МУЗГ-ын 2020 оны 6 дугаар сарын 23-ны өдрийн 232 дугаар тогтоолоор Бүтээгдэхүүн хуваах гэрээг цуцалсан. (Хуучин нэр нь "Ди Дабль Юэ Эм Петролеум Аг" "Цагаан элс XIII" "Зүүнбаян ХИҮ" талбай) 2014 оноос хойш хайгуулын үйл ажиллагаа явуулаагүй.
2	Вульфпетролеум ХХК	921,126,100.00	АМГТГ-ын даргын 2022 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 1/6195 дугаар тай албан бичгээр Сүхбаатар ХХVII талбайн БХГ-г дүгнэж, УУХҮЯ-ны 2023 оны 07 сарын 04-ний өдрийн А/247 дугаар тушаалаар Сүхбаатар ХХVII талбайн БХГ-ний хугацаа дуусгавар болсонтой холбогдуулан нээлттэй сонгон шалгаруулалт зарласан. 2019 оноос үйл ажиллагаа явуулаагүй.
3	Шунхлай Энержи ХХК	778,339,629.65	Газрын тосны салбарт Бүтээгдэхүүн хуваах гэрээгээр 2019-2020 онд хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчдийн нийт хөрөнгө оруулалт, нөхөгдөх зардлын баталгаажуулалтын аудитын тайланд 01/А0150046 АХГ-2022/10-НА-СТА дугаар төлбөрийн актыг тогтоосон. 2016-2022, 2024-2025 онуудад хайгуулын үйл ажиллагаа явуулаагүй.
4	Ренова-Илч ХХК	622,382,500.00	МУЗГ-ын 2022 оны 9 дүгээр сарын 5-ны өдрийн 337 дугаар тогтоолоор Бүтээгдэхүүн хуваах гэрээг цуцалсан. Бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулсан боловч хайгуулын үйл ажиллагаа явуулаагүй.
5	Өмнөд монголын газар нутгийн тос ХХК	680,253,467.10	МУЗГ-ын 2022 оны 9 дүгээр сарын 5-ны өдрийн 337 дугаар тогтоолоор Бүтээгдэхүүн хуваах гэрээг цуцалсан. 2016 оноос хойш хайгуулын үйл ажиллагаа явуулаагүй.
6	ХонгКонг Вэлпэк Индастриал	764,682,466.39	МУЗГ-ын 2022 оны 9 дүгээр сарын 5-ны өдрийн 337 дугаар тогтоолоор Бүтээгдэхүүн хуваах гэрээг цуцалсан. Бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулсан боловч хайгуулын үйл ажиллагаа явуулаагүй.

7	Голден сий петролеум ХХК	51,428,853.63	АМГТГ-ын даргын 2025 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн А/198 дугаар тушаалаар газрын тосны хайгуулын Галба XI, Тариач XV талбайн Бүтээгдэхүүн хуваах гэрээний биелэлтийг дүгнэж, 2026 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн албан бичгээр АҮЭБЯ-д хүргүүлсэн. 2011-2025 онуудад хайгуулын үйл ажиллагаа явуулаагүй.
8	Сансарын геологи хайгуул ХХК	1,264,447,025.00	МУЗГ-ын 2020 оны 6 дугаар сарын 23-ны өдрийн 232 дугаар тогтоолоор Бүтээгдэхүүн хуваах гэрээг цуцалсан. 2016 оноос хойш хайгуулын үйл ажиллагаа явуулаагүй.
9	Шейман ХХК	607,236,697.39	АМГТГ-ын даргын 2022 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн 1/1797 дугаар тай албан бичгээр Нялга XVI талбайн БХГ-г дүгнэж, УУХҮЯ-ны 2023 оны 07 сарын 04-ний өдрийн А/249 дугаар тушаалаар Нялга XVI талбайн БХГ-ний хугацаа дуусгавар болсонтой холбогдуулан нээлттэй сонгон шалгаруулалт зарласан. 2014 оноос хойш хайгуулын үйл ажиллагаа явуулаагүй.
<b>НИЙТ</b>		<b>8,109,827,446.86</b>	